



Нээлттэй Нийгэм Форум

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

МОНГОЛД ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙН
ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН ЭРХ ЗҮЙН БОЛОН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ АРГА ЗАМ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Бодлогын судлаач: Ч.БААЗАР
2007 оны Бодлогын судалгааны
тэтгэлэгт хөтөлбөрийн судлаач,
доктор (Ph.D)

Зөвлөх: Х.НАРАНЖАРГАЛ
“Глоб интернэйшнл” ТББ-ын тэргүүн

Улаанбаатар
2008 он

DDC
XXX.X
X-XX



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Монгол Улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

Уг судалгаагаар гаргасан дүгнэлт, саналууд нь
судлаачийн үзэл бодлыг илэрхийлнэ.

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл ННФ-ын хаягаар
хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Энэ судалгааны тайланг сонирхсон байгууллага, хувь хүмүүст хямдралтай үнээр
худалдана.

ISBN 978-99929-0-XXX-X

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

Талархал	vi
НЭГ. Судалгааны хэрэгцээ буюу удиртгал	1
ХОЁР. Бодлогын судалгааны арга зүй	3
2.1. Судалгааны таамаглал	3
2.2. Судалгааны арга зүй.....	4
2.2.1. Шинжилгээ хийх нэгж.....	4
2.2.2. Тохирох кейс.....	4
2.2.3. Тайлбарлах ба хянагч хувьсагч.....	4
2.3. Мэдээлэл цуглуулах аргууд	5
ГУРАВ. Чөлөөт хэвлэл, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн өнөөгийн байдал	6
3.1. Чөлөөт сэтгүүл зүй хөндлөнгийн хяналтын хараат бус механизм болох нь.....	6
3.2. Тулгарч буй асуудлуудын тойм	8
3.3. Бид өнөөдөр хаана явна вэ?.....	9
ДӨРӨВ. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйд нөлөөлж буй хүчин зүйлсийн дүн шинжилгээ	11
4.1. Хууль эрх зүйн орчин	12
4.1.1. Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах, нууцлах тухай асуудал.....	12
4.1.2. Эрүүгийн хууль дахь зарим заалтыг өөрчлөх тухай асуудал	16
4.2. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт	22
4.2.1. Редакцийн хараат бус байдлын тухайд.....	22
4.2.2. Сэтгүүлчийн өөрийн цензурын тухайд	26
4.2.3. Сэтгүүлчийг эрэн сурвалжлах арга барилд сургах, мэргэшүүлэх.....	29

ТАВ. Дэвшүүлж буй бодлогын хувилбар: эрх зүйн таатай орчин болон бие даасан хараат бус бүтэц, ...	32
5.1. Эрэн сурвалжлах бие даасан, хараат бус бүтэц, бусдын туршлага	33
5.2. Бие даасан, хараат бус институцийн үүрэг, бүтэц, үйл ажиллагаа	38
ЗУРГАА. Дүгнэлт.....	40
6.1. Эрх зүйн орчин.....	40
6.2. Редакцийн хараат бус байдал.....	42
6.3. Сэтгүүлчийн өөрийн цензур.....	42
ДОЛОО. Зөвлөмж	45
Ном зүй	49

Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
МУИХ	Монгол Улсын Их Хурал
МХХ	Монголын Хэвлэлийн Хүрээлэн
МоСХ	Монголын Сонины Холбоо
МСНЭ	Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл
МУҮИС	Монгол Улсын Үндэсний Их Сургууль
МҮЭ	Монголын Үйлдвэрчний Эвлэл
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн Бус Байгууллага
ХМХ-	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ФЭССЗТ	Филиппиний Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төв
ЭССЗ	Эрэн сурвалжлах сэтгүүл зүй

ТАЛАРХАЛ

Бодлогын судалгааг амжилттай хэрэгжүүлж, өмнөө тавьсан судалгааны зорилтуудыг биелүүлэхэд тусалсан байгууллага, хувь хүмүүст гүн талархал илэрхийлье! Дэмжлэг, зөвлөгөө, санал бодлоо хэлсэн олон хүнээс онцгойлон Будапешт дэх Нээлттэй Нийгмийн Хүрээлэнгийн “Орон Нутаг, Төрийн Үйлчилгээний Шинэчлэлийн Санаачилга” хөтөлбөрийн сургагч багш Оун Янг, Канадын Карлтоны Их Сургуулийн Төрийн бодлого, удирдлагын тэнхимийн багш доктор Лесли Пал, зөвлөхөөр ажилласан “Глоб Интэрнэшнл” ТББ-ын Тэргүүн Х.Наранжаргал, сэтгүүл зүйн доктор Л.Норовсүрэн, До.Цэнджав, сэтгүүлч Цог. Ганболд нарт чин сэтгэлийн гүнээс талархаж байна. Нээлттэй Нийгэм Форум нь 2007 оны Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөртөө эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжлийн асуудлыг багтаан уг судалгааг дэмжсэнээрээ энэхүү салбарт маш том дэмжлэг үзүүлж байгааг талархан тэмдэглэж байна.

Миний судалгааны ажлыг дэмжиж оролцсон байгууллага, хувь хүмүүс нь үүгээрээр Монголын ардчиллыг бэхжүүлэх, хөгжүүлэхийг зорьж байгаа хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн гэж ойлгож байна. Учир нь ардчиллыг чөлөөт хэвлэлээс, чөлөөт хэвлэлийг ардчиллаас салгаж үл болно. Чөлөөт хэвлэл нь ардчилал оршин байгаагийн илэрхийлэл бол эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь чөлөөт хэвлэлийн хамгийн эрхэм зорилго болох ард түмний эрх ашгийн үүднээс төрд хяналт тавих үүргээ гүйцэтгэх арга замуудын нэг нь юм. Төрийн хязгааргүй эрх мэдлийг хазаарлаж, албан тушаалтнуудын хууль бус үйлдлийг илчилж, улмаар нийгэмд цэвэр тунгалаг, ил тод, шударга ёсыг тогтооход эрэн сурвалжлах сэтгүүл зүй ус агаар шиг хэрэгтэй байна. Энэ ч утгаараа сэтгүүл зүйг дөрөв дэх засаглал гэж нэрлэдэг билээ. Ардчилсан Монголд сайн засаглалыг хөгжүүлжн бэхжүүлэхийн төлөө байгаа та бүхний дэмжлэг, туслалцаа ажил хэрэг болж, бие даасан, хараат бус эрэн сурвалжлах үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн болон үйл ажиллагааны орчин бүрдэнэ гэдэгт судлаачийн хувьд итгэлтэй байна. Дахин талархъя!

Доктор. Ч.Базар (Ph.D)

НЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЦЭЭ БУЮУ УДИРТГАЛ

Өнөөдөр Монголын улс төр, нийгмийн амьдрал ихээхэн ээдрээтэй байдалд байна. Эрх мэдэлтнүүд албан тушаалаа ашиглан авилга, хээл хахууль авч, шударга бус шийдвэрээрээ нийгмийн баялгийн тэгш хуваарилалтыг алдагдуулж байгаа тухай хардлага сэрдлэг их байгаа боловч түүнийг баримтаар нотолсон мэдээ, мэдээлэл төдийлөн гарахгүй байна. Энэ нь төр засаг, төрийн албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж олон нийтэд мэдээлэх бүтцүүд үр дүнтэй ажиллаж чадахгүй байгаагийн илрэл гэж үзэж болно.

Энэ бол эрэн сурвалжлах сэтгүүл зүйн гүйцэтгэх ёстой чиг үүрэг мөн. Зүй нь авилга, хээл хахууль, шударга бус үйлдэл тогтолцооны шинжтэй болсон өнөө үед эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь нийгэмд шударга ёсыг тогтооход ихээхэн үүрэг гүйцэтгэх учиртай билээ. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь:

- Албан тушаалтнуудын хаацайлан далдлахыг хүсч буй шударга бус, хууль зөрсөн үйлдэл, шийдвэр зэргийг ил гаргаж тавих;
- Мэдээлэгдэхгүй байгаа “хаалттай” сэдвийг дэлгэж олон түмний анхаарлыг татах;
- Дэвшүүлж байгаа бодлого, шийдвэрийн үр дагавар, нөлөөг олон нийтийн эрх ашгийн үүднээс үнэлж дүгнэх зэрэг асуудлыг баримт, нотолгоонд тулгуурлан олны анхааралд хүргэх замаар нийгэмд шударга ёсыг тогтоох үйл хэрэгт олон нийтийг үнэн бодит мэдээллээр “зэвсэглэх” хөндлөнгийн, хараат бус хяналтын чиг үүргийг гүйцэтгэдэг.

Харин тодорхой албан тушаалтан, төрийн байгууллагын алдаа оноог баримтад тулгуурлан шүүн тунгааж олон нийтэд хүргэх үүрэгтэй сэтгүүл зүйн энэ төрөл өнөөдөр манайд төдийлөн хөгжөөгүй зогсонги байдалтай байгааг өдөр тутмын хэвлэлд гарч байгаа олон нийтлэлээс дээрх зорилгод нийцсэн баримтад материал бараг алга байгаагаас харж болно. Яагаад эрэн сурвалжлах сэтгүүл зүй зогсонги байна вэ? Түүний хөгжлийг саарахад ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ гэдгийг судалж, бодлогын арга хэрэгслээр энэ төрлийн сэтгүүл зүйг дэмжин хөгжүүлэх боломж байгаа эсэхийг тодорхойлох хэрэгцээ илт харагдаж байна. Үүсээд байгаа өнөөгийн эрх зүйн болон үйл ажиллагааны орчинд үнэлгээ өгсөн

судлаач, шинжээчдийн дүгнэлт, сэтгүүлчдийн санал бодлоос нэгтгэхэд энэ байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг гадаад болон дотоод хүчин зүйлс гэж ангилж харж болох байна. Гадаад хүчин зүйлсэд юуны өмнө хууль эрх зүйн таагүй орчинг нэрлэсэн байхад, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны орчин буюу редакцийн хараат байдал, сэтгүүлчийн өөрийн цензур, мэргэжлийн ур чадвар дутмаг зэрэг нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд сөргөөр нөлөөлж буй дотоод хүчин зүйлсэд багтсан байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөллийг засаж залруулах бодлогын тодорхой алхмуудыг хэрэгжүүлснээр эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь төрийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хараат бус хяналт тавих үүргээ бодитойгоор хэрэгжүүлэх таатай орчин бүрдэнэ гэсэн дүгнэлтэд судлаач миний бие уг бодлогын судалгааг гүйцэтгэх явцдаа хүрлээ.

Судалгааны хүрээнд хэвлэлийн эрх чөлөөт үйл ажиллагааг зохицуулж буй хууль эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ сэтгүүлч, судлаачдаас судалгаа авч, энэ чиглэлээр өмнө нь хэрэгжүүлсэн судалгаа, мониторингийн ажлын дүнг нэгтгэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн өмнө тулгараад байгаа бэрхшээлүүдийг тодорхойллоо. Судалгааны хүрээнд санал зөвлөмж боловсруулах, бодлогын хувилбарыг гаргахдаа Монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний орчин, хууль эрх зүй, редакцийн хараат бус байдал, сэтгүүлчдийн хүсэл, эрмэлзлэл зэргийг тусгахын сацуу ардчиллын замаар хөгжиж байгаа бусад улс орны хууль эрх зүйн орчин, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлж буй арга технологи, механизм зэргийг тоймлон багтаахыг хичээсэн болно.

ХОЁР. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү бодлогын судалгааны зорилго нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд саад учруулж буй хууль эрх зүйн болон үйл ажиллагааны түвшний хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр уг салбарыг Монголд хөгжүүлэхэд дэмжлэг болох бодлогын хувилбарыг тодорхойлоход оршиж байв. Бодлогын судалгааны дээрх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- Эрх зүйн орчин: Чөлөөт хэвлэл болон эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үйл ажиллагаанд нөлөөлж буй хууль эрхийн актуудад шинжилгээ хийх
- Институцийн орчин: Сэтгүүлчдийн ажиллаж буй орчин буюу хэвлэл мэдээллийн хэрэгслийн (ХМХ) редакцийн хараат бус байдалд дүн шинжилгээ хийх
- Сэтгүүлчдийн сэдэл: Сэтгүүлчдийн эрэн сурвалжлах ур чадвар, онолын мэдлэг болон дадлага туршлагын түвшний талаар сэтгүүлчид өөрсдөө ямар үнэлгээ дүгнэлттэй байгаа болон тэдний хүсэл сонирхлыг тодорхойлох
- Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд нөлөөлж дээрх хүчин зүйлсэд үнэлгээ өгсний үндсэн дээр энэ салбарын хөгжлийг дэмжих бодлогын хувилбар дэвшүүлэх
- Санал болгож буй бодлогын хувилбарыг хэрэгжүүлэх алхмуудыг санал болгох зэрэг болно.

2.1. СУДАЛГААНЫ ТААМАГЛАЛ

Хэвлэл мэдээллийн харилцааны өнөөгийн байдлыг аваад үзэхэд нэг талаасаа хэвлэлийн хэт эрх чөлөөт байдлаас болж сонин хэвлэлээр баримт нотолгоогүй материалыг тараах нөхцөл үүсэх тул үүнийг хатуу хуулиар зохицуулах ёстой гэсэн нэг байр суурь байхад нөгөө талаасаа хатуу хууль нь хэвлэл мэдээллийн ажилтнуудыг төр, захиргааны байгууллага, албан хаагчдын хяналт дор оруулах тул хараат бус хяналтын үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрнэ гэсэн байр суурь байна. Тэгвэл чөлөөт сэтгүүл зүйн хяналтын үүрэг функцийг дэмжсэн эрх зүйн таатай орчинд

сэтгүүлчид ёс зүйн өөрийн зохицуулалтын зарчмаар ажилладаг олон орны туршлага байгаа бөгөөд харин энэ механизмыг тууштай мөрдөж байгаад хяналт тавих үүргийг сэтгүүлчийн бие даасан, хараат бус бүтцээр дамжуулан хэрэгжүүлснээр өнөөдөр эрэн сурвалжлах сэтгүүл зүйг Монголд хөгжүүлэх боломж байна гэсэн таамаглалыг дэвшүүлж байна.

2.2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.2.1. Шинжилгээ хийх нэгж

1992-2008 оны хооронд Монгол Улсын Их Хурлаас батлагдан гарсан хууль, тогтоол, шийдвэрт хэвлэлийн болон сэтгүүлчийн эрх, эрх чөлөөний талаар заасан заалт нь шинжилгээний нэгж болно.

2.2.2 Тохирох кейс

Бодлогын судалгааны кейс нь 1992-2006 оны хоорондох чөлөөт хэвлэл, сэтгүүлчийн мэдээлэл олж авах, хэвлэн нийтлэх, нууцлах эрх, эрх чөлөөг зохицуулсан хуулиудад ТББ-ууд, судлаачдын хийсэн дүн шинжилгээ, судалгааны материал байв. Түүнчлэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлж байгаа ардчилсан орон болон өмнө нь манайх шиг тогтолцоотой байсан пост коммунист орнуудын жишээг ашиглав.

2.2.3. Тайлбарлах ба хянагч хувьсагч

Бодлогын судалгаанд харьцангуй богино хугацаанд бодлогын арга хэрэгслээр буюу хууль, тогтоол, институцийн түвшний өөрчлөлт зэргээр дамжуулан өөрчилж болох нөхцөл байдлыг бодлогын хувьсагч гэж үзээд, харин харьцангуй олон талт нөлөөллийн үр дүнд өөрчлөгдөх түүх, соёл, нийгмийн харьцаа, хандлагыг нөхцөл байдлын хувьсагч гэж авч үздэг.

Бодлогын хувьсагч. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйд нөлөөлж буй олон хүчин зүйл байгаагаас бодлогын судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаагаар өөрчлөх боломжтой хувьсагчаар эрх зүйн орчны өөрчлөлт шинэчлэл, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг дэмжсэн хараат бус бүтцийг байгуулах арга, механизмыг боловсруулах, эрэн сурвалжлагч сэтгүүлчдийн үр чадвар, дадал туршлагыг нэмэгдүүлэх боломж, бололцооны асуудлыг авч үзлээ.

Нөхцөл байдлын хувьсагч. Харин харьцангуй богино хугацаанд өөрчлөх боломжгүй нөхцөл байдлын хувьсагчаар редакцийн хараат бус байдлыг бий болгох, чөлөөт хэвлэлийн хөгжилд нөлөөлж буй улс төр, эдийн засаг, соёлын бусад хүчин зүйлсийг оруулсан болно.

2.3. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГУУД

Судалж буй асуудлыг онцлогоос шалтгаалан судалгаанд тоон мэдээллийн аргыг хязгаарлагдмал хэмжээнд ашигласан болно. Монголд чөлөөт сэтгүүл зүйг хөгжүүлэх зарчмын асуудлаар судалгаа, дүн шинжилгээ харьцангуй их байгаа тул судалгаанд анхдагч мэдээллийн хэрэгцээ бага, дийлэнхдээ хоёрдогч мэдээллийг нэгтгэх, харьцуулах, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онцлогтой уялдуулан дүгнэлт хийх чиглэлээр уг судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Анкетын арга: Сэтгүүлчдээс эрэн сурвалжлах сэтгүүл зүйг чиглэлээр ажиллах сонирхол хэр байгааг нь асуухын зэрэгцээ саад болж байгаа хүндрэлүүдийг нь нэрлүүлэх зорилготой анкетын асуулга явуулсан ба гарсан үр дүнг нэгтгэн, судалгааны тайланд танилцууллаа.

Контент анализын арга: Чөлөөт хэвлэл, сэтгүүлчийн мэдээлэл олж авах, хэвлэн нийтлэх, нууцлах эрх, эрх чөлөөг зохицуулсан хуулиудад ТББ-ууд, судлаачдын хийсэн дүн шинжилгээ, судалгааны дүгнэлтийг харьцуулан судлав. Мөн судалж байгаа асуудлын хүрээнд гадаадын болон дотоодын туршлагыг судлах зорилгоор хууль, баримт бичиг, судалгаа шинжилгээний материал, илтгэл, тайлан зэргийг хэвлэмэл болон интернетэд тавигдсан байдлаар судлан шинжлэв.

Ганцаарчилсан ярилцлага: Судалгааны хүрээнд экспертүүдтэй ганцаарчлан уулзаж, ярилцлага хэлбэрээр тэдний санал, дүгнэлт, туршлага зэргийг судлан бодлогын баримт бичигтээ ашиглав.

Бүлгийн ярилцлага: Судалгаанд холбогдох асуудлаар Хөвсгөл, Орхон аймаг, нийслэлийн өдөр тутмын болон 7 хоног тутмын сонины сэтгүүлчидтэй уулзан, бүлгийн ярилцлага хэлбэрээр тэдэнд учирч буй бэрхшээл, санал, зөвлөмжийг судлан, бодлогын баримт бичигтээ ашиглав.

ГУРАВ. ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ, ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3.1. ЧӨЛӨӨТ СЭТГҮҮЛ ЗҮЙ ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН ХАРААТ БУС МЕХАНИЗМ БОЛОХ НЬ

Аливаа ардчилсан төрд хууль тогтоох, шийдвэр гаргах үүрэг хариуцлагыг сонгогдсон болон томилогдсон албан тушаалтнууд гүйцэтгэж, тэдгээрийн үйл ажиллагааг шүүх хяналтын тогтолцоо нь хянаж байх үүрэгтэй. Ардчилсан төрийн энэ сонгодог тогтолцоо нь эрх мэдлийг төрийн гурван өндөрлөг буюу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалд салган оногдуулах замаар харилцан хяналттайгаар ажиллах зарчимд тулгуурладаг. Төрийн эрх мэдэл ард түмний гарт байх ардчилсан засаглалын концепцийн дагуу төрийн гурван өндөрлөг буюу салбарын аль аль нь ард түмний сайн сайхны төлөө, нийтийн эрх ашигт үйлчлэх үүргээ өөрсдөө үнэнчээр гүйцэтгэхийн зэрэгцээ бусад хоёр салбар нь энэ үүргээ хэр үнэнчээр биелүүлж байгаад хяналт тавьж ажиллах зарчимтай.

Харин сэтгүүл зүйг дөрөв дэх засаглал гэж нэрлэдэг нь зүгээр нэг нэр төдий биш юм. Олон түмэнд мэдээллийг хүргэх хамгийн түргэн шуурхай, өргөн далайцтай арга хэрэгслийн хувьд сэтгүүл зүйн салбар нь төрийн албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ дүгнэлт өгч, нийтийн эрх ашигт хэр үнэнчээр үйлчилж байгаад нь хараат бус шинжилгээ хийж, мэдээллээ олон нийтэд шууд хүргэдэг утгаар нь ийнхүү дөрөв дэх засаглал гэж нэрлэдэг ажээ. Энэхүү энгийн тайлбараас харахад сэтгүүл зүйн салбарын нэг чиг үүрэг нь олон нийтийн өмнөөс төрийн албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хараат бус хяналт тавих чиглэл болж байна.

Чөлөөт хэвлэлийг төлөвшүүлэх нь ардчиллын тулгуур хүчин зүйл мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх нь төр засаг хийгээд сонин хэвлэл эрхлэн гаргагчдын хүсэл зориг, улс төрийн эрмэлзлэлээс ихээхэн хамааралтай гэдгийг Өрнөдийн орны чөлөөт хэвлэлийн түүх бэлхнээ харуулдаг. АНУ-ын XIV дэх Ерөнхийлөгч Абрахам Линкольн “Өөрийн дайснаа ч чөлөөт хэвлэлтэй байлгахын төлөө амь насаа зориулахад бэлэн байна”¹

¹ Ардчилал гэж юу вэ? Америкийн мэдээллийн агентлаг. 1991

гэж уриалж байсан бол Францын их хувьсгалын нэрт зүтгэлтэн, улс төрийн удирдагч М.Робеспьер энэ байр суурийг баттай баримтлагч байж “Хэвлэлийн эрх чөлөө гэдэг бол бүх төрлийн үзэл бодлыг чөлөөтэй нийтлэх явдал”² хэмээн тунхаглаж байсан нь чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшилд ихээхэн нөлөөлсөн юм.

Монгол Улсад ардчиллын хөгжилтэй зэрэгцэн чөлөөт хэвлэлийн төлөвшил явагдаж байна. Нэг радио, нэг телевизтэй, цөөн хэдэн сонин нь төвлөрсөн хатуу хяналт, удирдлагатай байсан үеийг бодвол манай улсын мэдээллийн зах зээл дээр өнөөдөр 69 сонин, 50 телевиз, 63 радио, кабелийн 16 телевиз³ тогтмол буюу тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Хэвлэл мэдээлэлд хэн юу хүссэнээ бичиж, мэдээллийн зах зээл дээрх тооны өсөлт, өрсөлдөөн нэмэгдсэн юм шиг эерэг дүр төрх харагдана. Олон нийт ч хэрэглэгчийн үүднээс хэвлэл, сонинг идэвхтэй худалдан авч, улмаар олон янзын мэдээлэл хүлээн авч байгаагаараа тэдэнд хүрэх мэдээллийн хэмжээ эрс нэмэгдэж, олон янзын байр суурь илэрхийлэгдэж хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал хангагдаж байгаа мэт. “Хэн юу хүссэнээ бичиж, нийтэлж, үгээ чөлөөтэй хэлж байна” гэсэн халхавч хүчтэй байна.

Гэтэл ардчилсан сэтгүүл зүйн зарчим талаас нь харахад дээрх байдал чөлөөт хэвлэлийн төлөвшилд ихээхэн сөрөг үр дагаврыг бий болгожээ. Ардчиллын үнэт зүйлс нь хүний эрх, эрх чөлөөн дээр суурилдаг бөгөөд тэрхүү эрх бодитой хэрэгжиж, хүлээн зөвшөөрөгдөж буй нэг хэлбэр нь хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадаж байна уу, үгүй гэдгээр хэмжигдэх нь зүйн хэрэг. Өөрөөр хэлбэл, хөндлөнгийн нөлөөнөөс ангид, чөлөөт хэвлэл мэдээлэл нь чөлөөт сонгуулийн нэгэн адил төр засгийн үйл хэргийг ард түмний хүсэл эрмэлзэл, эрх ашгийн үүднээс явуулахын баталгаа болдог байна. Үүнийг товчоор чөлөөт хэвлэл бол чөлөөт ард түмэн хэмээн томъёолж болох юм. Гэтэл “чөлөөт” учраас “юу хүссэнээ...” гээд баталгаа нотолгоо муутай мэдээлэл гаргах нь олон нийтийг төөрөгдүүлэхийн зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг нь бууруулах муу талтай. Давтан хэлэхэд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүртээмж, хамрах цар маш их тул олон нийтэд үзүүлэх нөлөө нь тэр чинээгээрээ хүчтэй байдаг бөгөөд түүнийхээ хэрээр төрийн үйл ажиллагаанд хяналт тавихад тус болох үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүргэдэг иргэдийн оролцооны нэг механизм юм. Үүн дотроо эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь далдлан халхлах сэдэл сонирхлын эсрэг тэмцэх зорилготой тул баталгаатай анхдагч мэдээллийг хангаж өгсөн эх сурвалж,

² Мөн тэнд

³ Хэвлэл мэдээллийн мониторингийн судалгаа, УБ., МХХ, 2007

түүнийг олон нийтийн хүртээл болгож байгаа сэтгүүлч хоёроос иргэний зориг шаардсан давхар эрсдэлтэй үйл ажиллагаа юм.

Хориод жилийн түүхтэй Монголын чөлөөт хэвлэлийг энэ утгаар нь авч үзвэл хөгжил, төлөвшил нь ихээхэн ээдрээтэй байна. Өнөөдөр манайд ажиллаж байгаа өдөр тутмын 10 гаруй сонины редакцийн бүтцэд нэг сониноос бусад нь Эрэн сурвалжлах албатай байна. Харин нийтлэл мэдээллийг нь задлан шинжилж үзэхэд баттай баримт, хөдөлшгүй нотолгоон дээр тулгуурласан дүн шинжилгээний нийтлэл, нэвтрүүлэг ховор байна. Сэтгүүл зүй судлаач, доктор Т.Баасансүрэн “...Нэг талаас харахад Монголд чөлөөт сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн эрх чөлөө байгаа юм шиг харагдана. Нөгөө талаас авч үзвэл байхгүй, нэлээд хаалттай, хязгаарлагдмал болох нь аяндаа мэдрэгдэнэ. Ийм гайхалтай, хоёрдмол шинж төрхтэй, сэтгүүл зүйн онол, практикийн үүднээс задалж үзвэл тун сонирхолтой цаг үед Монголын сэтгүүлчид аж төрж, туурвин байгаа юм”⁴ гэж хэлсэн нь анхаарал татсан дүгнэлт мөн. Эндээс харахад либерал, чөлөөт өрсөлдөөнт хэвлэл мэдээллийн зах зээл маань үнэн хэрэгтээ хаалттай, хяналттай, чөлөөт бус орчин юм биш байгаа гэж дүгнэхэд хүргэж байна.

3.2. ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУДЫН ТОЙМ

Юуны өмнө эрх зүйн орчны нөлөөлөл хамгийн чухал нөлөөтэй байна гэж дүгнэж байгаа учраас чөлөөт сэтгүүл зүй, үүний дотор эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд дэмжлэг болох эрх зүйн орчинг авч үзлээ. Өнөөдрийн байдлаар тогтолцооны шинжтэй эрх зүйн 2 зангилаа асуудлыг шийдвэрлэхгүйгээр чөлөөт сэтгүүл зүйн хөгжлийг ярихад төвөгтэй болж байна. Үүнд: мэдээлэл авах, өгөх, нийтлэхтэй холбоотой чөлөөт орчныг бүрдүүлэх; нөгөө нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдэд тавих хяналтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар бус харин хэвлэл мэдээллийн өөрийгөө зохицуулах механизмаар дамжуулан хэрэгжүүлэх зэрэг болно.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн Хуулинд иргэд мэдээллийг олж авах, эрж хайх, түгээх, нийтлэх эрхийг тунхагласан боловч эдгээрийн хэрэгжилтийг зохицуулалтгүй орхисноос тунхаг төдий л үлджээ. Жишээлбэл, төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэд олж авах эрхийн хэрэгжилтийг зохицуулах Мэдээллийн эрх чөлөөний тухай зэрэг зарчмын хуулиуд батлагдаагүй хэвээр байгаагийн улмаас албан тушаалтнууд төрийн үйл хэрэг хэрхэн хэрэгжиж байгаа, тэдэнд хамаатай ямар хууль, шийдвэр,

⁴ Баасансүрэн Т. Сэтгүүлчийн ур чадварын тухай яриа. УБ., 1999

тогтоол гарсан талаарх мэдээллийг авах гэсэн иргэддээ татгалзсан хариу өгөх, хариулахгүй байх зэрэг үйлдэл гарсаар байна. Зүй нь төрийн үйл хэргийг ард түмний нэрийг өмнөөс зохион байгуулан хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчид өөрийг нь сонгосон ба томилсон иргэддээ бүрэн мэдээлэл өгч байх зарчимтай. Энэ нь зөвхөн төрийн нууцад хамаардаггүй зохицуулалт юм байна. Энэ утгаараа мэдээллийн эрх чөлөө бол иргэдийн оролцооны чухал суурь нөхцөл, харин хэвлэл мэдээллийн эрх чөлөө бол хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх нэг арга зам нь юм. Энэ өнцгөөс харвал, жирийн иргэн мэдээлэл авах эрхтэй байх ёстой шиг хэвлэл мэдээллийн ажилтан сэтгүүлч, сурвалжлагчид мэдээлэл олж авах, түүнийгээ түгээн нийтлэхийн зэрэгцээ эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онцлогийн улмаас эгзэгтэй сэдвээр мэдээлэл өгсөн эх сурвалжаа нууцлах, хамгаалах эрхтэй байх ёстой.

Сэтгүүлчийн бэлдэж боловсруулсан мэдээллийг нийтлэхтэй холбоотойгоор редакцийн хараат бус байдлын асуудал сөхөгддөг. Үүнд сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэн, эзэмшигчийн байр суурь нөлөөлөх асуудал гардаг.

Хараат бус үйл ажиллагааны практик тал нь хараат бус санхүүжилтийн асуудал юм. Чөлөөт хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны санхүүжилт төрөөс бус өөр эх үүсвэрээс орж ирж байх нь зүйтэй гэсэн зөвлөмж байдаг (жишээлбэл, “Хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизм буюу Хэвлэлийн консулуудын харьцуулсан судалгаа”, 2006 он) ч тодорхой арга замуудыг судлах шаардлагатай байна.

3.3. БИД ӨНӨӨДӨР ХААНА ЯВНА ВЭ?

Хэвлэл мэдээллийн хөгжил, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төлөвшил нь хэвлэлийн эрх чөлөөг хангаж өгөх төрийн бодлогоос ихээхэн хамаатай байна. Өнөөдөр Монголд эдийн засаг, эзэмшлийн хувьд бүрэн биеэ даасан, улс төрийн нам, хүчний нөлөөллөөс ангид, ил тод байдал, олон ургальч үзлийн индэр болсон, хууль эрхийн баталгаатай, төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар нийгмийн эрх ашигт үйлчилдэг чөлөөт хэвлэлийн тогтолцоо бүрдэж чадаагүй байна. Өөрөөр хэлбэл, чөлөөт хэвлэлд үзүүлэх улс төр, эдийн засгийн нөлөө хүчтэй хэвээр байна. Энэ байдал нь редакцийн хараат бус байдлыг алдагдуулж байна. Хараат байгаа тохиолдолд мэдээллийн үнэн бодит байдалд эргэлзээ төрдөг. Хараат байхад албан тушаалтан, эрх мэдэлтний хууль зөрчсөн шударга бус үйлдлийг олон түмэнд дэлгэнэ гэдэг бүр ч эргэлзээтэй. Тэр дундаа чөлөөт хэвлэлийн өөрийнх нь мөн чанар, баталгаа байж, цаашлаад мэргэжлийн хүрээнд төдийгүй нийгэм дэх нэр төр, бахархал нь болдог

эрэн сурвалжилсан сэтгүүл зүй хөгжихөд саад тотгор их байна.

Шүүмжилж, олны анхааралд хүргэж байгаа зарим нийтлэл мэдээллийн сэдэв нь яах аргагүй нийгмийн ашиг сонирхлыг хөндсөн байх боловч асуудлын хойноос гүнзгийрүүлэн судалсан, баримтын үнэн зөв, баттай нотолгоонд тулгуурласан зэргийг нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн арга барилын үүднээс задлан шинжлэхэд ихээхэн эргэлзээ төрүүлдэг. Мөн зарим нийтлэл нь эх сурвалжаас хараат буюу захиалгат бичлэг үү, эсвэл сэтгүүлчийн уйгагүй эрэн сурвалжлагын үр дүн үү гэдгийг сэтгүүл зүйн үүднээс ялгахад ч төвөгтэй байдал үүсгэдэг.

Тийм учраас судлаач миний бие эрэн сурвалжлах сэтгүүл зүйн энэхүү ээдрээт байдал нь юунаас шалтгаалж байна, түүнийг хөгжүүлэх ямар арга зам байна гэдгийг судлан, өөрчлөх боломжит хувилбарыг бодлогын хэмжээнд гаргаж тавихыг чухалчиллаа.

ДӨРӨВ. ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйд саад болж буй хүчин зүйлсийг хэвлэл мэдээллийн гадаад, дотоод орчинтой холбон үзэх нь энэхүү сэтгүүл зүйн цаашдын хөгжилд ихээхэн тустай билээ.

- Гадаад орчинд хэвлэлийн эрх чөлөө, мэдээлэл авах эрх, эрх чөлөө, мэдээллийн эх сурвалжаа хамгаалах, нууцлахыг дэмжсэн эрх зүйн орчинг багтааж үзлээ. Монгол улсад өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн баримт бичгүүд нь хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл зүй тэр дундаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд нөлөөлж байгаа байдал, ардчилсан тогтолцоотой бусад оронд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хэрхэн зохицуулж буйг харьцуулан судалж үзэхэд зарим өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага байгаа нь харагдлаа.
- Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн дотоод орчин буюу өөрийн зохицуулалтын өнөөгийн байдлыг редакцийн хараат бус байдал, сэтгүүлчийн өөрийн цензур асуудалтай холбон дүн шинжилгээ хийлээ. Редакцийн хараат бус байдал нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд нөлөөлөх анхдагч бодит хүчин зүйл юм. Мөн сэтгүүлчийн өөрийн цензур ч гэсэн редакцийн хараат бус байдлаас ихээхэн шалтгаалдаг. Эдгээрийг хууль эрхийн актаар зохицуулдаггүй бөгөөд үүнд гагцхүү ардчилсан сэтгүүл зүйн өөрийн зохицуулалт голлох үүрэгтэй байдаг.
- Түүнчлэн хэвлэл мэдээллийн дотоод орчинд эрэн сурвалжлах сэтгүүлчдийн чадавх буюу мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, тэдний хүсэл зориг, ур чадварын асуудал ч ихээхэн хамаатай асуудал мөн.

4.1. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“Мэдээлэл олж авах, эх сурвалжаа нууцлах, сэтгүүлчээ хамгаалах хуулийн орчинг бий болгож чадвал эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжинө” гэж судлаачид, сэтгүүлчид үздэг. Сэтгүүлч Г.Энхбаатар “Эрэн сурвалжлагч сэтгүүлч нь нэг ёсондоо мөрдөн байцаагч шиг ажиллах ёстой гэнэ. Тэрбээр аливаа эрэн сурвалжилж буй зүйлийнхээ хойноос уйгагүй хөөцөлдөж, баримт материал цуглуулж, эх сурвалжуудтай уулзаж, зураг хөргийг нь авч, дуу хуурыг нь бичиж, арай л хурууных нь хээг буулгах нь холгүй байх ёстой юм байх. Өнгөцхөн сонсвол болмоор ч юм шиг. Гэтэл тийм бишээ. Хүний хойноос хөөцөлдөхөөр мөрдөн мөшгөлт болчихдог, баримт материал цуглуулахаар улсын болон хувийн нууц руу халдсан болдог, зураг хөргийг нь авчихаар хүний эрхэд халдсан болдог, дуу хуурыг нь бичихээр хууль бус үйлдэл болдог ийм л зүйл заалт өнөөдөр үйлчилж байна” хэмээсэн нь өнөөгийн сэтгүүлчдэд учирч буй бүхий л бэрхшээлийг тодотгосон үг юм. Эдгээр дүгнэлтэд мэдээлэл олж авах нийтлэг эрхийн зэрэгцээ эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онцлог болсон (а) Баримт нотолгоо, мэдээ, мэдээллийг иргэний эр зориг гарган хуваалцсан эх сурвалжаа нууцлах эрх, (б) эрэн сурвалжлах нийтлэлийг бэлтгэн гаргасан сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хэрэгтэй байгааг харуулж байна.

4.1.1. Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах, нууцлах тухай асуудал

Эх сурвалжийг хамгаалах явдал эрэн сурвалжлах сэтгүүл зүйд яагаад чухал байдаг вэ?

Сонгогдсон болох томилогдсон албан тушаалтнуудын хууль бус үйл ажиллагаа, алдаатай шийдвэр, үйлдлийн тухай мэдээлэл тэр бүр ил, нээлттэй мэдээлэгддэггүй тул нотлох баримтыг гаргаж өгсөн эх сурвалжаа болзошгүй эрсдэлээс хамгаалах үүднээс нууцлах шаардлага гардаг.

Өнөөдөр Монгол улс Улсын Үндсэн Хууль, болон “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай”, “Авилгын эсрэг” хуулиудад мэдээлэл авсан, өгсөн эх сурвалжийг нууцлах эрхийн талаарх заалт тусгагдаагүй байна. Бодит байдал дээр сэтгүүлчид мэдээллийн эх сурвалжаа илчлэх, хэрэв илчлэхгүй бол хариуцлага хүлээлгэх тулгалт, шаардлагыг шүүх, хуулийн байгууллагаас байнга сонсох болсныг олон баримт нотолж байна. 2002 оноос хойш Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлээр зөвхөн сэтгүүлчид шийтгэгджээ. байна. Тухайлбал, “Үг” сонины эрхлэгч Б.Ханддолгор, “Монголын нэг өдөр” сонины сурвалжлагч А.Эрдэнэтуяа нар баривчлах ялаар, “Урт чихт” сонинд ажиллаж байсан Ч.Лхагва, Ц.Ууганбаяр, Т.Түвшин,

Д.Жаргалсайхан, “Өдрийн сонин” сонины тоймч Г.Дашрэнцэн нар торгуулийн ялаар тус тус шийтгэгдэж, цөөнгүй тооны хүнийг эрүүгийн хэрэгт татан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд олон цөөн хоногоор шалгаж иржээ. Сэтгүүлчдэд хууль, цагдаагийн байгууллагын хамгийн түрүүн тулгадаг асуулт, шахалт шаардлага нь “мэдээллийг хаанаас авсан, хэн өгсөн тухай” юм.

Эх сурвалжаа нууцлах эрх нь нэг талаасаа нийгмийн эрх ашгийн үүднээс нотолгоо мэдээллээр хангаж өгсөн хүний аюулгүй байдал, нөгөө талаасаа сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой хоёр талт асуудал юм. Албан тушаалтан, эрх мэдэлтнүүдийн булхайтай болон буруутай үйлдлийг илчилсэн хүн элдэв дарамт, өшөө авалт, айлган сүрдүүлэгтэй тулгарах магадлалтай. Харин сэтгүүлч нь хүний итгэлийг хүлээж олж авсан мэдээллийнхээ эх сурвалжийг ямар ч тохиолдолд чанад нууцлах ёс зүйн үүргээ биелүүлэх ёстой. Үүнд хуулийн хамгаалалт шаардлагатай.

Эрх зүйн ийм зохицуулалтыг дэлхийн 100 орчим орон бий болгожээ. Үүнээс бараг 20 улс орон Үндсэн Хуульдаа хамгаалсан бол 80 гаруй нь Хэвлэлийн, Эрүүгийн болон Иргэний хуульд тухайлсан заалт оруулан баталгаажуулжээ. Мөн олон муж улстай орны онцлогоос хамааран холбооны улс хоорондын хуулиар зохицуулсан жишээг АНУ, Аргентин, Мексик, Австрали болон Германаас харж болно. Ялангуяа сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц дэвшил гарч, Мексик, Шинэ Зеланд, Австрали, Эль Сальвадор, Швейцарь, Бельги зэрэг оронд шинээр хууль баталсан байна. Мэдээллийн эх сурвалжаа нууцлах, хамгаалах сэтгүүлчийн эрхийг Европын Хүний Эрхийн Шүүх “Хэвлэлийн эрх чөлөөний тулгын чулуу”⁵ хэмээн үзсэн байдаг бөгөөд нилээд орон энэхүү эрхийг хүлээн зөвшөөрчээ. Австри улс 1981 оны Хэвлэл мэдээллийн хуульдаа “Хэвлэл мэдээллийн ажилтан, хэвлэн нийтлэгчид эх сурвалжийг илчлэх, мэдээллийн агуулгыг задруулахаас татгалзах эрхтэй”⁶ гэж заажээ. ХБНГУ-ын хэвлэлийн хууль нь эх сурвалжаа хамгаалах эрхийг нэлээн өндөр түвшинд баталгаажуулж, мэдээлэгч нь гэмт хэрэгт сэжиглэгдсэн байлаа ч түүнийг илчлэхгүй байх эрхээр сэтгүүлч хангагдсан байна. Норвегид сэтгүүлчийн эх сурвалж маш ноцтойгоос бусад тохиолдолд хуулиар хамгаалагдана гэж заагаад хуулийн байгууллага сэжиглэгдсэн хүнийг олж тогтоохыг хүссэн тохиолдолд л сэтгүүлч эх сурвалжаа илчлэхийг хүсэж болно гэж хуульдаа тусгажээ. Пост коммунист зарим оронд ч дэвшил гарсан бөгөөд тухайлбал Чех улс 2000 онд баталсан хуульдаа тодорхой хязгаарлагдмал нөхцөлд тухайлбал,

⁵ Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээлэлд чадварыг бий болгогч орчинг бүрдүүлэх нь. УБ., 2007

⁶ Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээлэлд чадварыг бий болгогч орчинг бүрдүүлэх нь. УБ., 2007

үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, газар нутгийн бүрэн бүтэн байдал, олон нийтийн аюулгүй байдал, шүүхийн эрх мэдэл, шударга ёсыг хэрэгжүүлэх үүднээс нууц эх сурвалжийг хамгаалахтай холбоотой заалт оруулсан байна. Шведэд эх сурвалжийн хамгаалалт нь мэдээллийн эрх чөлөөтэй хамт үг хэлэх эрх чөлөөг баталгаажуулсан өргөн тогтолцоо бүхий хууль тогтоомжийн нэг хэсэг бөгөөд урьдчилсан хязгаарлалт байдаггүй. Хэвлэлийн эрх чөлөөний хуулиар албан ёсны баримт бичгүүд олон нийтэд нээлттэй байдаг. Хуулиар туйлын хязгаарлагдмал тохиолдлоос бусад үед хүссэн хүн бүрт тэдгээр баримт бичгийг үзэхийг зөвшөөрдөг. Эх орноосоо урвах ба өөр ноцтой гэмт хэргээс бусад тохиолдолд тэдгээр баримт бичигт агуулагдсан мэдээллийг төрийн төрийн албан тушаалтнууд заавал илчлэх үүрэг хүлээдэг байна.

Улсын нэр	Хууль тогтоомж	Тодорхой заалт
Испани	Үндсэн хууль	Сэтгүүлч эх сурвалжаа нууцлах эрхтэй
Португали	Үндсэн хууль, Хэвлэлийн хууль, Сэтгүүл зүйн хууль	Эх сурвалж хамгаалах зарчмыг хүлээн зөвшөөрсөн. Сэтгүүлч эх сурвалжаа хамгаалах эрхтэй.
Австри, Дани, Финлянд, Франц, Герман, Итали, Литва, Норвеги, Польш, Швед, Их Британи	Эрүүгийн хууль	Сэтгүүлч эх сурвалжаа нууцлах, хамгаалах эрхтэй
Австри	Хэвлэл мэдээллийн хууль	Хэвлэл мэдээллийн ажилтан, хэвлэн нийтлэгчид эх сурвалжийг илчлэх, мэдээллийн агуулгыг задруулахаас татгалзах эрхтэй
Их Британи Умард Ирландын Вант улс	Шүүхэд үл хүндэтгэл үзүүлэх тухай	Баруун Европтоо хамгийн цогц тогтолцоотой орон. Нэр дурьдсан хуулийн 10-р зүйлд “сурвалжлагчийн дуугүй байснаас үүдэн үндэсний аюулгүй байдал, гэмт хэргийн илрүүлэлт, түүнээс урьдчилан сэргийлэх ажил, шударга ёсны эрх ашигт аюул занал учруулахаас бусад тохиолдолд сэтгүүлчийг нууц мэдээллээ илчлэхийг албадах ёсгүй.

Герман	Хэвлэл мэдээллийн хууль, Эрүүгийн хууль	Сэтгүүлчийн эх сурвалжаа хамгаалах эрхийг нилээд өндөр түвшинд баталгаажуулсан. Мэдээлэгч нь гэмт хэрэгт сэжиглэгдсэн байлаа ч түүнийг илчлэхгүй байх эрхээр сэтгүүлч хангагджээ.
Норвеги	Эрүүгийн хууль	Сэтгүүлчийн эх сурвалж маш ноцтойгоос бусад тохиолдолд хуулиар хамгаалагддаг. Цагдаа сэжиглэгдсэн хүнийг олж тогтоохын тулд л эх сурвалжаа илчлэхийг хүсэж болно.

Харин Монголд шүүхээс өмнө, шүүх дээр сэтгүүлчдээс эх сурвалжаа илчлэхийг шаардах нь энгийн үзэгдэл болжээ. “Хэн энэ мэдээллийг өгсөн бэ?” гэдэг нь сэтгүүлчийн бичсэн шүүмжлэлт материалд эмзэглэн гомдол мэдүүлэгч, түүнийг өмгөөлөгч, шүүгчдийн хамгийн эхний асуулт болдог аж. Тухайлбал, “Үг” сонины ерөнхий редактор асан Б.Хандолгорыг мэдээлэл өгсөн эх сурвалжаа илчлэхийг шаардан улмаар түүнийг Эрүүгийн хуулийн зүйл заалтаар ялласан. Мөн 2007 онд “Зууны мэдээ” сонины сэтгүүлч Л.Цогнэмэхийг УИХ-ын гишүүний нэхэмжлэлээр эрүү үүсгэн байцаахдаа эх сурвалжаа илчлэхийг удаа дараа шаардаж байжээ. Хамгийн ноцтой нь эх сурвалжаа илчлэхийг шаардахдаа хүмүүс гол төлөв шүүх цагдаагаар баривчлуулахаар сэтгүүлчийг сүрдүүлдэг байна. Шүүх, цагдаа хуулийн байгууллагын энэхүү дарамт сүрдүүлэг нь сэтгүүлчийн хараат бус ажиллах зарчмыг алдагдуулж, улмаар үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрхийг зөрчихөд хүргэдэг.

Зарим нэг ахиц манайд бас гарч байна. 2006 онд УИХ-аар батлагдсан “Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн тухай” хуулинд мэдээлэл олж авах эрх, мэдээллийг олон нийтийн хүртээл болгох эрх, мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийн талаар дурьдсан нь тодорхой дэвшил боловч энэ нь зөвхөн олон нийтийн радио телевизийн ажилтнуудад хамаатай хязгаарлалттай заалт гэж ойлгогдохын зэрэгцээ тууштай нэг мөр ойлгон хэрэглэхэд учир дутагдалтай болжээ. Тодотговол, дээрх хуульд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгохоос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан нь нэг талаасаа нууцлах эрхтэй, нөгөө талаасаа нууцлах ёсгүй ч юм шиг давхар утгыг агуулж байна. Тэгээд ч энэ нь дээр дурьдсанчлан

Монголын нийт сэтгүүлчдийн хувьд мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх зүйн чадамжгүй заалт юм. Гэхдээ ойролцоо үйлдлүүдэд хуулийн зүйл заалтыг дүйцүүлэн хэрэглэдэг туршлага бас бий. “Эрүүгийн хэргийг байцаан шийтгэх тухай Монгол улсын хууль”-д сэтгүүлчдийн үйл ажиллагаатай холбоотой ганцхан зүйл байгаа нь “Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх” гэсэн заалт бөгөөд доторх агуулга нь ердөө л “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, эсвэл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол...” албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай ажээ. Харин сэтгүүлчийг өөрийг нь хамгаалсан ямар ч зүйл заалт дээрх хуульд байхгүй байна.

Сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагуудын дүрэм, журамд дээрх байдлыг хэрхэн зохицуулсныг судалж үзэхэд Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлээс баталж гаргасан “Монголын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим”-д “эх сурвалжаа нууцална” гэсэн заалт оржээ. Гэвч Монгол улсын хуулиар зохицуулаагүй нөхцөлд энэхүү баримт бичгийг бүхэлд нь болон тодорхой зүйл заалтыг нь шүүх үйл ажиллагаан дээр эх сурвалж болгон хэрэгсэх нь эргэлзээтэй.

Санал болгож буй хувилбар

Нууц эх сурвалжийг хамгаалах талаарх эрх зүйн үндсийг бүрдүүлэх. Түүний үндсэн зарчим нь эх сурвалж болох аливаа этгээд нэрээ нууцлах тулгуур эрхтэй байх ба энэ эрхийг сэтгүүлч зөрчвөл хариуцлага хүлээх, сэтгүүлч эх сурвалжаа нууцлах тулгуур эрхтэй байх, эх сурвалжийн нэрийг зөвхөн үндэсний аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, олон нийтийн аюулгүй байдал асуудал зэрэг хязгаарлагдмал нөхцөл байдлаас бусад тохиолдолд хатуу хамгаалах, сэтгүүлчээс мэдээллийн эх сурвалжийг задруулахыг Засгийн газар, шүүх шаардахыг хориглох зэрэгт тулгуурлавал зохино. Энэхүү эрх зүйн зарчмыг Мэдээллийн эрх чөлөөний, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулинд тодорхой оруулж өгөх шаардлагатай байна.

4.1.2. Эрүүгийн хууль дахь зарим заалтыг өөрчлөх тухай асуудал

Яагаад Эрүүгийн хуулиас Гүтгэлэг, Доромжлолтой холбоотой заалтыг хасаж, Иргэний маргаан үүсгэн шийдвэрлэх боломжийг хайх ёстой вэ?

Эрүүгийн хуулиар хүний нэр төр, алдар хүндэд муугаар нөлөөлсөн гэж үзсэн маргааныг шийдвэрлэх нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчдийн олон нийтийн ашиг сонирхолд хамаатай асуудыг сөхөж тавихаасаа өмнө шоронд хоригдох, эсвэл ихээхэн хэмжээний мөнгөн торгуулийн шийтгэлээс болгоомжилсон өөрийн цензурийг бий болгох хандлагыг ихэсгэж, эцэст нь үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрх хязгаарлагддаг.

Эрэн сурвалжлах сэтгүүлчдэд дарамт, айдас болгоомжлол байнга үүсгэдэг хууль бол “Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх тухай Монгол улсын хууль” юм. Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлээр хүний нэр төр, алдар хүндийг доромжилсон, хүнийг гүтгэсэн утгатай зүйлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тараасан бол гэмт хэрэг гэж үзэн торгох, баривчлах ял шийтгэх талаар заажээ. Энэхүү гүтгэлэг, доромжлолын тухай заалт нь хүний эрх, нэр хүндийг хамгаалахад чиглэгдсэн утгатай мэт боловч хажуугаар нь Монгол Улсын Үндсэн Хуулиар олгогдсон “Монгол улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх”-тэй мөн харшилдах байдлаар ашиглаж болох боломжтой юм. Дээрх заалт нь эрх баригчид, албан тушаалтан, төр засгийн байгууллагын талаар шүүмжлэлт материал бичсэн сэтгүүлчдийн эсрэг ашиглахад тэдэнд хуулийн илүү боломж олгож байгаа нь судалгаанаас харагддаг. Аливаа шүүмжлэгдсэн этгээд өөрийгөө доромжлогдсон, гүтгэгдсэн гэж үзвэл цагдаа, прокурорын байгууллагад гомдлоо гаргаж, шүүхэд хандан хэрэг үүсгүүлдэг хандлага бэхжин хэвших вий гэсэн болгоомжлол төрж байна.

БАРИМТ 1. *“Глоб Интернэшнл” ТТБ-ын хуульчдын хийсэн судалгаагаар 2001-2005 онд гүтгэлэг, нэр төр, доромжлолтой холбоотой 187 хэрэгшүүхээр шийдвэрлэгдсэн байна. Үүнээс 178 нь иргэний, 9 нь эрүүгийн хэрэг байв. Хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эсрэг хэрэг 151 байснаас 146 нь иргэний, 5 нь эрүүгийн хэрэг байна. Эдгээр хэргийн 59.6 хувь нь улс төрч, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллагын нэхэмжлэлээр шийдвэрлэгджээ. Иргэний хэргийн 45 нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, тэдний санааг зовоосон асуудлаар, 32 нь улс төрч, албан тушаалтан, албан хаагчдын буруу үйлдэл, авилга, хээл хахуультай холбогдуулан, 10 нь тэдний хувийн амьдралын тухай бичиж нийтэлсэн материал байжээ.*

Эх сурвалж: “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө Монголын өнөөгийн байдал”, 2007, х 23

Монгол Улсын Үндсэн Хуулийн 10-р зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтална...”, 2 дахь хэсэгт “Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударга сахин биелүүлнэ”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн заалтыг өнөөдөр мөрдлөг болгох шаардлагатай байна. Үзэл бодол, түүнийг илэрхийлэх эрх чөлөөний НҮБ-ын Тусгай мэдээлэгч Абид Хуссейн, OSCE-ийн Хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч Фреймут Дюв, OAS-ийн Хэвлэлийн эрх чөлөөний тусгай мэдээлэгч Сантьяго Кантон нар Лондонд 2000 оны 11-р сард ТББ, ЮНЕСКО, Сэтгүүлчдийн нийгэмлэг, Хүний эрхийн мэргэжилтнүүдтэй уулзсаны дараа хамтарсан Тунхаг гаргажээ. Тэрхүү Тунхагт “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөт урсгал дэлхийн олон оронд хямралт байдалд байна. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэх явцад нь сэтгүүлчид болон бусад хүмүүсийг дайран давшлах (цензурдах), гүтгэлэг, доромжлолын хязгаарлагдмал хуулиар хохироох зэрэг хоёр хэлбэрийн түгшүүрээр илэрч байна” гэдгийг онцлон дурьдаад “Тишүүн орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийг үл хязгаарлахын тулд гүтгэлгийн эсрэг хуулиа эргэн нягталж, олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлэх нь зүйтэй” гэдгийг сануулсан байна. Энэ нь 2002 онд Лондонд төвтэй 19-р зүйл байгууллагаас хийсэн “Монгол улсын Эрүү, Иргэний хуулийн гүтгэлэг, нэр төрийн талаарх заалтуудыг зайлшгүй өөрчлөх шаардлагатай” гэсэн дүгнэлттэй утга ижил юм. (“Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол улсын хуулиудад хийсэн дүн шинжилгээ” нэртэй баримт бичгийн 8-р бүлэг).

Эдгээрээс харахад доромжлол, гүтгэлгийн шинжтэй гэмт үйлдлийн тухай заалтыг Эрүүгийн хуульд оруулж, түүнийгээ сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбон хэрэглэх нь олон улсад тэвчишгүй зөрчилд тооцож, үүний учир шалтгааныг ч тодорхой тайлбарлажээ. Ийм зохицуулалтаар сэтгүүлчийн хэвлэн нийтлүүлсэн мэдээ, материалыг үндэслэлгүйд тооцон шүүхэд нэхэмжлэх гаргах замаар сэтгүүлчийг эрүүгийн хэрэгтэн болгодог. Улмаар эрүүгийн хэрэгт татагдахаас эмээсэн сэтгүүлчид шүүмжлэлт нийтлэл гаргахаас эмээн өөрийн цензур гэж нэрлэдэг зарчмаар алдаа дутагдал, буруу болон хууль бус үйлдлийг илрүүлэх үйл ажиллагаанаас сайн дураараа татгалзах, огт хийхгүй байх нөхцөл үүсэх юм.

Энэ нь ардчилсан нийгэм дэх олон ургальч үзэл, төрийн үйл хэрэгт хяналт тавих эрх, хэвлэн нийтлэх эрхийг нь боогдуулах сөрөг үр дагаврыг авчирч байна. Нөгөө талаар ардчилсан нийгэм дэх хэвлэл мэдээллийн

олон түмний өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу авилга, шударга бус үйлдэл, гэмт хэрэг, хүний эрхийн зөрчил зэрэг аливаа нуугдмал, бугшмал баримт сэлтийг сурвалжлан илрүүлэх, эрэн сурвалжилж олон нийтэд дэлгэн тавих шүүмжлэлт сэтгүүл зүйн зарчимд харшилж, сэтгүүлчдийн мэргэжлийн эрхээ эдлэх боломжийг хязгаарлахад хүргэж байна. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн санал бодол “Олон нийтэд мэдээлэл хүргэснийхээ төлөө эрүүгийн хэрэгтэн болж, хариуцлага хүлээх ёсгүй” гэдэг дээр нэгдэж байгаа бөгөөд тэд “Хэрэв өнөөдөр эрэн сурвалжлах сэтгүүл зүйн материал бичвэл Монголын сэтгүүлчдийг Эрүүгийн хуулиар хамгийн түрүүнд “Доромжлох”, “Гүтгэх” цаашилбал “Гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг зөрчих”, “Хувь хүний нууцыг задруулах”, “Зориуд худал мэдээлэх” гэх мэт гэмт хэрэг үйлдсэн гэж, Иргэний хуулиар “Ажил хэргийн алдар хүнд, нэр төрийг гутаасан” гэсэн ял зэм хүртэж, Эрүүгийн хуулийн хөнгөн, хүндэвтэр, хүнд зүйл заалтуудаар, Иргэний хуулийн үлэмж хэмжээний торгууль шийтгэлээр яллуулах нөхцөл хүлээж байна”⁷ гэж өнөөдрийн нөхцөл байдалд дүгнэлт хийж байна.

БАРИМТ 2. *Хүний нэр төр, алдар хүндийг гүтгэх, доромжлох үйлдлээр эрүү үүсгэгдсэн хэргийн судалгааг 1995-2006 оны байдлаар авч үзэхэд дийлэнх нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажилладаг сэтгүүлчийн нэр дээр холбогдуулан эрүү үүсгэн шалгажээ. Ийм тохиолдол 1995 онд 3, 1996 онд 8, 1997 онд 6, 1998 онд 9, 2000 онд 10, 2001 онд 13, 2002 онд 9, 2003 онд 11, 2004 онд 18, 2005 онд 19, 2006 онд 6 удаа гарчээ.*

2002 оноос хойш Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлээр зөвхөн сэтгүүлчид шийтгэгдсэн байна. Тухайлбал “Үг” сонины эрхлэгч Б.Ханддолгор, “Монголын нэг өдөр” сонины сурвалжлагч А.Эрдэнэтуяа нар баривчлах ялаар, “Урт чихт” сонинд ажиллаж байсан Ц.Ууганбаяр, Т.Түвшин, Д.Жаргалсайхан, Ч.Лхагва нар, “Өдрийн сонин” сонины тоймч Г.Даширэнцэн нар торгуулийн ялаар тус тус шийтгэгдэж, цөөнгүй тооны хүнийг эрүүгийн хэрэгт татан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд олон цөөн хоногоор шалгаж иржээ.

Эх сурвалж: ХЗДХЯ-ны дэд сайд Ш.Сүхбаатарын “Нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад анхаарах зарим асуудал” илтгэлээс. “Глоб мэдээ” 2007, №8

⁷ Базар Ч. Бодлогын судалгааны явцад хийсэн тандалтын судалгаа. УБ., 2007

Харин судалгаанд хамрагдсан сэтгүүлчид өөрсдийн мэргэжлийн болон ёс зүйн зарчмаа зөрчсөн үйлдлийг зөвтгөөгүй нь анхаарал татаж байна. “Үнэхээр буруутай, хэн нэгнийг гүтгэсэн, худал зүйл бичсэн бол хариуцлага хүлээх нь зүйн хэрэг” гэдэгтэй тэд санал нийлж байна. Гэхдээ энэ асуудлыг Эрүүгийн хуулиар биш Иргэний хуулиар зохицуулах санал тавьж байгаа нь үндэслэлтэй зүйл юм. Нэр төр гэдэг нь иргэн, хүнтэй холбоотой нэр томъёо бөгөөд өөрөөр хэлбэл А гэдэг хүний нэр төрийн асуудал байж болохоос биш хэлтсийн дарга Б-ийн нэр төр гэсэн тусгайлсан ойлголт байдаггүй тухай нийтлэлч Б.Батбаяр (Баабар) бичсэн байдаг. Саяхны нэгэн тохиолдолд Францын Ерөнхийлөгч Николя Саркози өөрийнх нь зөвшөөрлийг авалгүйгээр зургийг нь сурталчилгаанд ашигласан компанийн эсрэг шүүхэд хандахдаа “Иргэн Н.Саркози” гэсэн нэрээр нэхэмжлэл гаргаж байсан. Үүнээс харахад олон улсын практикт иргэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд тухайн хүний албан тушаал хамаагүй зүйл болж, иргэний харилцаа гэж тооцогддог ажээ. Тэгэхээр манайд ч гэсэн иргэний нэр төрийг гутаан доромжлогдсон тухай хэрэг үүсгэхэд хүрвэл Эрүүгийн биш харин Иргэний хуулиар зохицуулах ёстой. Харин Иргэний хуулийн нэр төр гутаахын эсрэг заалт нь олон улсын хууль тогтоомжийн жишигт нийцсэн байх шаардлагатай байна. Тухайлбал, төр, төрийн байгууллага, төрийн бүх төрлийн албан тушаалтнууд нэр төр гутаасан тухай хэрэг үүсгэх эрхгүй байх, төрийн зүтгэлтнүүд иргэдтэй харьцуулахад илүү их шүүмжлэлийг хүлээн зөвшөөрдөг, тэвчдэг байх зарчмыг тусгах, үнэн зөв нь ямагт өмгөөлөх хэрэгсэл байх, нэхэмжлэгч олон нийтийн эрх ашигт хамаарал бүхий үйл явцын баримтын талаар худал гэж үзэж буйгаа нотлох үүргийг хүлээдэг байх, хэнийг ч үзэл бодлоо илэрхийлсний нь төлөө нэр төр гутаасан хэрэгт хариуцлагад татаж үл болно гэх мэт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах шаардлагатай байна.

Сэтгүүлчийн эрэн сурвалжлах үйл ажиллагаанд шууд харшилсан эдгээр заалтаас гадна Монгол Улсын Эрүүгийн хуулийн өөр хэд хэдэн заалт мөн л тодорхой хэмжээний саад бэрхшээл учруулах магадлалтай байна. “Эрүүгийн хэргийг байцаан шийтгэх тухай Монгол улсын хууль”-ийн 79 дүгээр зүйлийн нэгд “Гэмт хэргийн нөхцөл байдлын талаар энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу олж авсан баримт сэлт мэдээллийг нотлох баримт гэнэ” хэмээн заасан бол мөн зүйлийн дөрөвт “Нотлох баримт цуглуулах талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй” гэж заасан нь сэтгүүлчдийн цуглуулсан баримт яагаад ч нотлох баримтаар шүүхэд хэрэг үүсгэх боломжгүй байдал үүсэж мэдэхээр харагдаж байна.

Гүтгэлгийн хууль, харьцуулахад:

Улс орнууд	Гүтгэх, Доромжлох хэргийг эрх зүйгээр зохицуулдаг эсэх	Хамгийн сүүлд хэзээ гүтгэлэгийн эсрэг Эрүүгийн хуулийг хэрэглэсэн болох	Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл хэрэглэдэг эсэх	Хорих ялыг хэрэглэдэг эсэх
Канад	Тийм	1983 онд Эрүүгийн хуулиас хасах санал гаргасан	Тийм	Практикт ховор байдаг
Австрали	Тийм	50 жилийн өмнө	Тийм	Сүүлийн 50 жилд хэрэглээгүй
Норвеги	Тийм	2003 онд	Тийм	1933 оноос хойш оногдуулаагүй
Швед	Татгалзаж байгаа		Тийм	Татгалзаж байгаа
Финлянд	Тийм		Тийм	Татгалзаж байгаа
АНУ	34 мужид үгүй		Тийм	Татгалзсан
Итали	Тийм	50 жилийн өмнө	Тийм	Сүүлийн 50 жилд хэрэглээгүй
Монгол	Тийм	Байнга	Үгүй	Тийм

Дээр нь мөн хуулийн 83 дугаар зүйлийн хоёрт “Хохирогч мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тэр нь нотлох баримт болохгүй” гэсэн нь нэг талаасаа иргэд олон түмний өмнөөс хохирогч болж байгаа сэтгүүлч эх сурвалжаа зайлшгүй хэлэхээс нааш цуглуулсан аливаа баримт нь нотлох баримт болж чадахгүй гэдгийг хуульчилжээ. Нөгөө талаас мөн хуулийн 95 дугаар зүйлийн хоёрт “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх нь...нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ” гэж заасан нь сэтгүүлчдийн олж цуглуулсан баримт үнэлэмжгүй болж мэдэх эрсдэл харагдаж байна. Гэвч эдгээр заалт нь сэтгүүлчийн хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд саад хориг болохгүй юм. Зөвхөн сэтгүүлчийн нийтэлсэн баримтын дагуу олон нийт шахалт үзүүлж, шаардлага тавих замаар албан ёсны мөрдөн байцаах үйл ажиллагааг эхлүүлэх шаардлагатайг харуулж байна. Үүнийг ялангуяа Авилгатай тэмцэх газар анхааралдаа авах хэрэгтэй.

Санал болгож буй хувилбар

Олон нийтийн ашиг сонирхолд хамаатай асуудлаар хувь хүнийг ил тод, нээлттэй шүүн хэлэлцэх нь хувь хүний хариуцлага, хөгжил, түүний нэр хүнд, ажил хэрэгт төдийгүй нийгмийн шударга ёс, сайн сайхан, дэвшлийг хурдасгаж, бусад хүний эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлдгээрээ ардчилсан нийгэмд ач холбогдолтой болохыг үндэслэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас Гүтгэлгийн эсрэг заалтыг хасаж, маргааныг Иргэний хуулиар зохицуулах. Хуулинд төр, төрийн байгууллага, төрийн бүх төрлийн албан тушаалтнууд нэр төр гутаасан тухай хэрэг үүсгэх эрхгүй байх, төрийн зүтгэлтнүүд иргэдтэй харьцуулахад илүү их шүүмжлэлийг хүлээн зөвшөөрдөг, тэвчдэг байх зарчмыг тусгах, үнэн зөв нь ямагт өмгөөлөх хэрэгсэл байх, нэхэмжлэгч олон нийтийн эрх ашигт хамаарал бүхий үйл явцын баримтын талаар худал гэж үзэж буйгаа нотлох үүргийг хүлээдэг байх, хэнийг ч үзэл бодлоо илэрхийлсний нь төлөө нэр төр гутаасан хэрэгт хариуцлагад татаж үл болно гэх мэт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах зэргийг тусгах

4.2. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Чөлөөт хэвлэлийг жинхэнэ утгаар нь эрх чөлөөтэй болгохын тулд сэтгүүл зүйн бодитой оршин байхын нэг нөхцөл болсон өөрийн зохицуулалт хэрэгтэй байна. Өөрийн зохицуулалтын өнөөгийн байдал нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд хэрхэн нөлөөлж буйг редакцийн хараат бус байдал, сэтгүүлчийн өөрийн цензур, сэтгүүлчийн сургалтын байдалтай холбон авч үзлээ.

4.2.1. Редакцийн хараат бус байдлын тухайд

Өөрийн зохицуулалт юуны өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакцийн хараат бус байдлыг хангахад чиглэгддэг. Редакцийн хараат бус байдал нь чөлөөт хэвлэл оршин тогтнож байгаагийн чухал хэмжүүр бөгөөд энэ нь юуны өмнө тухайн хэвлэлийн нийтлэл, сэтгүүлчид мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа хэлбэрийн нөлөөллөөс ангид байх тухай ойлголт юм. Энэ талаар дэлхийн чөлөөт хэвлэлийн онолын материалд “Хэрвээ сонин нь биеэ даасан хараат бус юм бол түүнийг эрхлэн гаргаж байгаа хүн ямар ч улс төрийн нам, байгууллагатай холбоо сүлбээгүй байна. Тэрээр хэн нэгэн хүний төлбөртэй захиалгаар түүний таалалд нийцсэн зүйл нийтлэхийг татгалзана” гэж томъёолон тодорхойлсон байдаг.

Сонин хэвлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь үнэхээр бие даасан, хэн нэгэн эрх мэдэлтэн, ямар нэгэн улс төр, бизнесийн бүлэглэлээс хараат бус оршин тогтнодог бол түүнийг эрхлэн гаргаж байгаа эзэн нь мөн юунаас ч хамааралгүй, чөлөөт байх мөрдлөг Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үйлчлэхгүй байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд, ерөнхий эрхлэгч хүн аливаа нэгэн улс төрийн нам, бүлэглэлийн гишүүн байж, тэндээс улс төрийн сонгуульд нэр дэвшиж, тэдэнтэй ямар нэгэн ил, далд холбоо сүлбээтэй ажилладаг нь ч бодит зүйл болжээ. Аль нэгэн бүлэглэл, хэн нэгний захиалгаар төлбөртэй нийтлэл, мэдээлэл түгээх нь ч элбэг байна. Уг нь эсрэгээрээ бүлэглэлийн эрх ашигт захирагдсан төлбөрт нийтлэл хэвлэх бус эзэн, редактор, сэтгүүлчид ч сонирхлын зөрчил бүхий мэдээ, мэдээлэл нийтэд түгээхээс татгалзаж байж редакцийн хараат бус байдал хангагдах учиртай билээ.

Энэ байдал нь хэвлэл мэдээллийг хэрэгслүүд өнөөдөр эдийн засаг, санхүүгийн хувьд хараат байгаагаар тайлбарлаж болох бөгөөд энэ нь хэвлэл мэдээлэл жинхэнэ утгаараа чөлөөт байж чадахгүй байгаагийн илэрхийл юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл эдийн засаг ба нийтлэлийн сонирхлыг хооронд нь хатуу зааглаж чадсан тохиолдолд түүний хараат бус байдал хангагдана. Хэдийгээр тухайн нийтлэл, мэдээллийг хэвлэн нийтлэх нь сонин, телевизийн өөрийн бизнест ашиг тустай байлаа ч сонинд хэн нэгний ашиг сонирхлыг бүрэн илэрхийлсэн сурталчилгааны шинжтэй мэдээ, материалыг арилжааны замаар нийтэлсэн тохиолдолд эзэн хүн хэзээ ч сониныхоо нэр хүндийг өсгөж чадахгүй төдийгүй, харин өөрөө хараат болон хувирч буй юм. Хамгийн гол уршиг нь эдийн засгийн ашиг сонирхол нийтлэл мэдээллийн бодит үнэнийг орхигдуулж байгаад л оршино. Эдийн засгийн сул дорой байдал нь хэвлэл бие даан хөгжихөд бэрхшээл учруулдаг бөгөөд томоохон зар сурталчилгааг байнга нийтлүүлдэг байгууллагууд түүн дээр нь дөрөөлж хэвлэлийг хатуу хяналтдаа байлгахыг хичээдэг байна. Засгийн газарт ч энэ байдал ашигтай байдаг бөгөөд санхүүгээр дамжуулан өөрийн нөлөөгөө тухайн хэвлэлд бэхжүүлж авдаг. Өөрийн ашиг сонирхолд үйлчилсэн мэдээ, мэдээлэл бичүүлэхийн тулд улс төр, бизнесийн хүрээнийхэн цалин багатай сэтгүүлчдийг хахуульдах чиглэлээр ч ажилладаг байна.

Өнөөдөр Монголын мэдээллийн зах зээл дээр улс төрийн бүлэглэл буюу эрх мэдэлтэн, Засгийн газар, хэвлэл мэдээллийн эзэн хоорондын тохиролцоо улам хүчтэй болж байна. Улс төрийн зэрэгцээ санхүүгийн бүлэглэл ч хэвлэл мэдээлэлд хүчтэй нөлөөлж, ил далд хөрөнгө оруулалт хийж эхэлжээ. Үүний уршгаар сонин хэвлэлийн нийтлэл мэдээлэл

сонирхлын бүлгийн эх сурвалжаас ихээхэн хамаарах болж, улмаар хэвлэлийн гол бүтээгдэхүүн болох мэдээ, мэдээлэл эзнээсээ шууд хамааралтай болж, редакцийн хараат бус байдал алдагдаж, улмаар чөлөөт хэвлэл нь ард түмний хоточ нохой байх, олон түмэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа байх чадвар алдагдаж эхэлжээ. Үүнийг доктор Д.Цэмбэл “Төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн үүрэг бүхий чөлөөт хэвлэлийн маань зарим нь харин ч төр засгийн бодлогын үргэлжлэл, зарим нь улс төрийн аль нэг хүчин юмуу, бизнес, ашгийн байгууллагын хавсарга болж байна. Ингэснээр нийгмийн ухамсрыг төлөвшүүлэхээсээ илүү олон нийтийн санаа бодлын эсрэг түрэмгийлэл бий болгож байна”⁸ хэмээн томъёолжээ.

Харин манайд сонин хэвлэлийн эзэн, эрхлэн гаргагчид нь бизнесээ, ашиг

БАРИМТ 3. *2000 оноос хойш эдийн засгийн цензур нь арай өөр хэлбэртэй болсныг та бүхэн анзаарч байгаа байх. Төрийн эрх мэдлийг ээлжлэн барьдаг МАХН, АН-ын гол гол улс төрч, бизнесийн бүлэглэлийнхэн өөрсдийн мэдлийн ХМХ байгуулж, хяналтдаа байлгах хэлбэртүгээмэл болсон. Орон нутагт байгаа ХМХ-үүд төсвөөс хэдэн төгрөг авч санхүүжихийн тулд дуулгавартай байж, зөвхөн аймаг сумын захиргааны албан мэдээллийг нийтэлдэг, орон нутгийн дарга нарыг магтан дуулаачид болж хувирсан. Мөн зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрсдийн гол санхүүжүүлэгч болох зар сурталчилгаа өгдөг компаниудынхаа эрхшээлд орсон гэдгийг дурьдаж болох юм.*

Эх сурвалж: МҮОНТ-ийн ММ агентлагийн ерөнхий редактор Ц.Мөнхтөр. “Цензур ба Монголын хэвлэл мэдээлэл” илтгэлээс

орлогоо, менежментийн бодлогоо барих, сэтгүүлч сэтгүүл зүйн ажлаа мэддэг зааг ялгаа алга байна.

Судалгааны явцад хийсэн ярилцлагаас сонины эзэн, редактор болон эрэн сурвалжлагч сэтгүүлчдийн хооронд үүсдэг харилцаа буюу эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр ажиллах сонирхолтой сэтгүүлчдэд учирдаг саад бэрхшээлийг сэтгүүлчид өөрсдөө дараах байдлаар тодорхойлж байлаа. Үүнд:

- Сонины эзэн, редактор нь бодох эргэцүүлэхээс илүү тодорхойлон бичихийг, нөлөөллөөс илүү процессыг эрхэмлэдэг;
- Сонины эзэн, редактор жижиг сажиг зарим тохиолдолд зүй бус ч

⁸ Цэмбэл Д. Цэнджав До. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол практикийн асуудал. УБ., 2000,

гэж болохоор явдлын тухай мэдээ, мэдээллийг сониндоо гаргуулдаг мөртлөө нийгмийн тогтолцооны гажуудал эрх мэдэлтнүүдээс хамаатай асуудлыг нийтлэхээс ихэвчлэн татгалздаг;

- Сонины эзэн, редактор “нийгэм идэвхгүй” байгаагаар шалтаглан эрэн сурвалжлах ажил хийх нь үр дүнгүй гэж үзэн, тийм санаачилгыг тэр бүр дэмждэггүй;
- Сонины эзэн, редактор тулгамдсан асуудлыг нуух (зөрчил, маргаан үүсэхээс болгоомжлон) эсвэл анзаарахгүй дүр эсгэхийг (нийгмийн тусын тулд гэсэн шалтаг) хичээдэг;
- Сонины эзэн, редактор өөрийн нэр төр, албан тушаалд сэв суулгахгүйн тулд хурц асуудлаас тойрч дөлдөг;
- Сонины эзэн, редактор эрэн сурвалжлах ажил нь эдийн засгийн болон цаг хугацааны эрсдэлтэй гэж болгоомжилдог;
- Сонины эзэн, редактор реклам, сурталчилгааны орлогоо алдахаас эмээдэг,
- Сонины эзэн, редактор улс төрийн нам, хүчний гишүүн юмуу түүний нэрийн өмнөөс сонгуульд нэр дэвшиж байсан нь нөлөөлдөг зэрэг юм. Энэ бүхэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйг дэмжих хэвлэлийн эздийн тууштай хүсэл эрмэлзлэл сул байгааг харуулж байгаа юм. Түүний шалтгаан нь ердөө хараат байдал билээ. Монголд өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэгслийн монополийг хязгаарлах болон эзэмшлийн талаарх хууль алга байна. Ямар телевиз, сонин хэн гэдэг хүний эзэмшил болох талаар нийтэд ил тод зарласан мэдээлэл байхгүй байна. Албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэгт ч энэ талаар дурьдаагүй байна. Жишээлбэл, нэгэн телевизийн ярилцлагад Ерөнхийлөгч хүртэл өөрийн эзэмшлийн телевизийн сувгийн тухай тодорхой мэдээлэл хийсэн хэрнээ энэ тухайгаа Хөрөнгө орлогын мэдүүлэгтээ дурьдалгүй өнгөрчээ. Харин өдөр тутмын сонин, телевиз, радиогийн ард эрх мэдэлтнүүд байгаа, тэдгээрт томоохон хөрөнгө оруулалт хийсэн тухай албан бус мэдээлэл нэлээд байдаг. Уршиг нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн ард улс төр, санхүүгийн бүлэглэл хүчтэй үйлчилснээр редакцийн хараат бус байдал алдагдаж, улмаар үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрх хязгаарлагдаж байна. Тэгвэл энэ байдлаас хэрхэн гарах вэ?


Санал болгож буй хувилбар

Редакцийн хараат бус байдлын төлөө сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд ихээхэн санал санаачилга гаргаж ажиллах хэрэгтэй байна. Юуны өмнө МСНЭ, МҮЭ болон хэвлэл, сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллагууд хэвлэл мэдээллийн хэрэгслийн далд эздэд шахалт үзүүлэх, тэдгээрийн нэрийг олон түмэнд ил тод мэдээлэх алхмуудыг хийвэл чөлөөт хэвлэлийн төлөвшилтөд ихээхэн тус дөхөм үзүүлэх болно. Мөн МСНЭ болон мэргэжлийн эрх ашгийг хамгаалдаг байгууллагууд хамтран сонин хэвлэлүүдэд зориулж “Зар сурталчилгаа ба нийтлэл, мэдээллийн зааг ялгааг гаргах тухай” журам, “Засгийн газар ба бусад байгууллагатай олон нийтийн хэвлэл мэдээллийн талаар хамтарч ажиллах журам” зэргийг санаачлан өөрсдийн Их хурлаараа батлан, улмаар мөрдлөг болгон ажиллах

4.2.2. Сэтгүүлчийн өөрийн цензурын тухайд

Сэтгүүлчдийн дунд явуулсан судалгааны дүнгээс харахад Монголд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжихгүй байгаагийн өөр нэг бодит шалтгаан нь сэтгүүлчдийн айдас болгоомжлол, тэдэнд ирдэг болон ирэх магадлалтай дарамт шахалт ажээ. “Та бүхэн яагаад эрэн сурвалжилсан томоохон бүтээл хийхгүй байна вэ? гэсэн асуултад сэтгүүлчдийн хариулсан байдлыг доорхи графикаас харахад:

Та бүхэн яагаад эрэн сурвалжлах томоохон бүтээл хийхгүй байна вэ?



Сэтгүүлчдийн “амь насанд хохирол учирч болзошгүй ” хэмээх энэхүү болгоомжлол нь өнөөдөртөө Монголд тулгарч буй бодит байдал гэхээсээ илүүтэй олон улсын мэргэжил нэгт нөхдөд нь тохиолдож буй эмгэнэлт үйл явдал тэдэнд нөлөөлж байна гэж үзэх үндэстэй юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Анан 2003 оны 5 дугаар сарын 3 буюу дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан илгээлтдээ “... сэтгүүлч хүн амиа алдсан тухайн нөхцөл байдал бүрийг бид одоогоор мэдэхгүй байгаа, магадгүй, хэзээ ч олж мэдэхгүй байж болно. Харин дэлхийн өнцөг булан бүрт ажил үүргээ гүйцэтгэж яваад амиа алдсан сэтгүүлч, сурвалжлагчдын ихэнх нь авилга, хээл хахуулийн хэргийг илчилсэн, хуулийн, эсвэл хууль бус ашиг сонирхолд саад болсон, товчоор хэлбэл мэргэжлийнхээ үүргийг гүйцэтгэсний төлөө хувь хүнийхээ хувьд санаатай аллагын бай болсон гэдгийг Сэтгүүлчдийг хамгаалах хорооны ачаар бид мэдэж байгаа билээ”⁹ хэмээснээс тодорхой юм. Сэтгүүлчдийг хамгаалах хорооны мэдээлж байгаагаар 2005 оны сүүлчийн байдлаар 136 сэтгүүлч дээрх шалтгаанаар шоронд хоригдсон байна. Монголын сэтгүүлчдийн хувьд гэнэтийн байдлаар амь насаа алдсан тохиолдлууд байгаа ч тэр нь чухам гадны нөлөөтэй эсэхийг тогтоогоогүй байна. “Глоб Интернэшнл” ТББ Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын татварын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газруудтай холбоо бүхий ноцтой баримтууд дээр тулгуурлан өөрийн ажилладаг “Ийгл” телевизээр эрэн сурвалжлах чиглэлийн цуврал нэвтрүүлэг бэлтгэн гаргахаар хоёр сарын турш ажиллаж байсан сэтгүүлч Г.Батжав гэмт халдлагад өртсөн талаарх үйлдэлд судалгаа хийсэн байдаг. Тэрхүү судалгаанд “... Хэрвээ Батжавын эрх чөлөөнд халдсан этгээдүүд түүний хийж байсан мэргэжлийн ажилтай нь холбогдуулан гэмт үйлдэл хийсэн бол Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 139 дүгээр зүйлд заасан сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангасан байх үндэслэлтэй юм”¹⁰ гэсэн байдаг. Сэтгүүлчийн эрх чөлөөнд халдах явдал манайд нийслэл төдийгүй Эрдэнэт зэрэг орон нутагт мэр сэр гардаг. Энэ нь бичиж нийтэлснийх нь төлөө юу, эсвэл хувь хүмүүсийн хоорондын асуудал уу гэдэг нь учир битүүлэг хэвээр үлддэг билээ.

Нөгөө талаар айдас болгоомжлол нь сэтгүүлчийн мэргэжлийн эр зориг, хүсэл эрмэлзэл дутсантай холбоотой байж болох юм. Нийтийн ашиг сонирхлын үүднээс сэтгүүл зүйд шүүмжлэл, шинжилгээ бүхий мэдээлэл гол байр эзлэх ёстой юм бол тэр нь нийгмийн удирдлагын эрх ашигт тус нэмэр үзүүлэх, нийгмийг цэвэршүүлэхэд ус агаар мэт хэрэгтэй. Ингэж

⁹ “Өнөөдөр”. 2003. №156

¹⁰ Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, Монголын өнөөгийн байдал. “Глоб Интернэшнл” ТББ. “Нээлттэй Нийгэм Форум”, 2005

үзвэл мэдээ, мэдээллийг дамжуулагч сэтгүүлч хүнд эр зориг зайлшгүй хэрэгтэй юм. Ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүлчид шударга ёсыг зөрчсөн үйлдлийг мөрдөн мөшгөх хүсэл эрмэлзэл, ямар ч бэрхшээлтэй тулгарсан түүнийг даван туулах эр зоригтой байж амжилтад хүрнэ. Тийм тууштай байдал өнөөдөр Монголд ажиглагдахгүй байна. Ер нь сэтгүүлчийн айдас болгоомжлол бол хамгийн “харгис” цензур гэдэг. ОХУ-ын сэтгүүл зүйн нэрт судлаач, доктор, профессор Я.Н.Засурский “өөрийн цензур гэдэг бол тодорхой заавар шийдвэрийг биелүүлэхийг шаардаж буй тодорхой хүчний дарамтаар хийж буй өөрийн хязгаарлалт мөн”¹¹ гэж оновчтой томъёолсон байдаг. Энэ нь сэтгүүлч хүн өөрөө өөрийгөө хязгаарлах тухай ойлголт бөгөөд эрх мэдэлтний албан тушаалаа урвуулан ашигласан хэрэг, элдэв хуйвалдааны зах сэжүүрээс барьж авсан ч дарамт, шахалтаас болгоомжилж, олон түмний хоточ нохой байх үүргээ өөрөөсөө зайлуулж, түүнийг нуун дарагдуулахад хүргэдэг тохиолдол манайд цөөнгүй байдаг. Энэ утгаараа сэтгүүлчийн айдас болгоомжлол бол сэтгүүлчийн баримтлах “чухал мэдээг нуун дарж болохгүй” гэсэн зарчмаа зөрчин, өөрийгөө хянан цагдаж байгаа үйлдэл юм. Энэ нь тухайн хувь хүнд үзүүлж буй сөрөг үр дагавраас гадна үзэл бодлын ялгаа, зөрчил маргааныг эрүүл бусаар боон дарах хор уршгийг нийгэмд бий болгодог ажээ.

Сэтгүүлчид эрэн сурвалжлага хийдэггүй бас нэг шалтгаанаа редакц сэтгүүлчээ хамгаалж чадахгүй байгаатай холбон үздэг юм. Үүнтэй уялдаа бүхий нэг зүйл байгаа нь “эзний болон гадны дарамт шахалт” ажээ. Редакци сэтгүүлчээ хамгаалж байгаа нь нэгдүгээрт, шүүхийн өмнө хамгаалах, хоёрдугаарт, эрэн сурвалжилсан бүтээлийг нь нийтэлсэн эсэхээр илэрхийлэгдэнэ. Хэрвээ нэгдэх асуудлын тодотгол нь сэтгүүлчийн хариуцлагатай холбоотой гэж үзвэл харин хоёр дахь асуудлын хамаарал нь редакцийн бие даасан байдал болон цензуртай ихээхэн холбогдож ирнэ. Зах зээлийн чөлөөт өрсөлдөөн нь төрийн дарамтаас илүү шахалтыг хэвлэл мэдээлэлд авчирчээ. “Юу бичихийг зах зээл мэднэ, яаж бичихийг эзэн мэднэ” гэсэн Өрнөдийн зарим орны зарчим Монголын хэвлэлд хүчтэй үйлчилж байна. Дампууралд хүрэхгүйн тулд тэрчлэн улс төрийн аль нэг хүчинд дуулгавартай үйлчлэх үүднээс тухайн хэвлэл мэдээлэлд эзний цензур хүчтэй үйлчилж байгаа нь үнэн. Өөрөөр хэлбэл, сэтгүүлчийн үзэл бодол, мэргэжлийн эрх нь эзний хяналтаар хязгаарлагдаж байна гэсэн үг. Мөн сонинны эзэн эрэн сурвалжлах үйл явц ихээхэн цаг хугацаа, мөнгө санхүү шаарддаг ажил гэдгээр шалтаглан сэтгүүлчдэд урт хугацааны томилолт, түүнд нь тохирсон хөлс мөнгө, мөн гүнзгийрүүлсэн судалгаа хийхэд туслах эдийн засгийн дэмжлэг үзүүлэхээс татгалздаг байна. Мөн

¹¹ Засурский Я.Н. Сэтгүүлчийн эрх чөлөө, бие даасан байдал: өөрийн цензур, өөрийн хяналт. “Сэтгүүлч”, 1996. №1

ажиллаж буй хэлтэс, тасгийг нь өөрчлөх нэрээр тухайн сэтгүүлчийг халуун цэгээс холдуулдаг арга барил ч эздэд түгээмэл байна.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжихгүй байгаа болон сэтгүүлчид эрэн сурвалжлага хийх хүсэлгүй байдгийн бас нэг шалтгаан нь сөхөж тавьсан болон илчилж мэдээлсэн асуудлын мөрөөр хууль хяналтынхан ажилладаггүй, харин ч цагдаа, хууль, шүүхийн өмнө очоод замхардаг, эсвэл сэтгүүлчдэд буруу нь тохогддогээр тайлбарлагдах ажээ. Энэ бол үнэхээр ноцтой бөгөөд бодитой асуудал юм. Үнэхээр эрх мэдэлтнүүдтэй холбоо бүхий мэдээлэл сонин хэвлэлд гардаг ч түүний мөрөөр хууль хяналтынхан хэрхэн ажилласан, ямар хариуцлага хүлээлгэсэн зэрэг нь нийгэмд ил тод мэдээлэгдэхгүй өнгөрөх нь олонтаа байдаг. Нөгөө талаар нэг хэвлэлийн шүүмжлэлт мэдээллийг нөгөө хэвлэл нь эрс няцаасан, хамгаалсан нийтлэл, нэвтрүүлгүүд зэрэгцээд нийтэлчихдэг. Аль нь үнэн, худал болохыг нийгэм ялгаж салгаж чадахгүй байсаар тэдний хараа хяналт суларч, улмаар мартаход хүрдэг. Эцэст нь хүмүүс “энэ сониньхонд итгэх итгэл алга” хэмээн хэвлэлд бурууг өгөөд л орхидог сөрөг зуршил манайд газар авчээ. Энэ бүх бодит байдал нь үнэний төлөө дуугарах сэтгүүлчийг эргэлзээнд оруулж өөрөө өөрийгөө цензурдах шалтгаан болж байна. Өөрийн цензур нь редакцийн хараат бус байдалтай хамгийн их уялдаа холбоотой байдаг. Тогтолцооны зүгээс энэ асуудлыг авч үзвэл сэтгүүлчийн өөрийн цензур нь сэтгүүлчийг хамгаалах байгууллага, бүтэц байхгүй байгаатай холбоотой гэж дүгнэж болохоор байна. Сэтгүүлчийн хамгаалалт баталгаажуулаагүй нь мэргэжлийн ажилд саад болох бодит нөхцөл болж байгаа тухай сэтгүүлчидтэй хийсэн ярилцлагын үр дүн харуулж байна.

4.2.3. Сэтгүүлчийг эрэн сурвалжлах арга барилд сургах, мэргэшүүлэх

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй эрчимтэй хөгжиж чадахгүй байгаа орчны тулгамдсан асуудлыг арай өөр өнцгөөс буюу сэтгүүл зүйн сургалттай холбон авч үзье. “Манай оронд сэтгүүл зүйн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх сургалт 1960 оноос МУИС-д эхэлж өнөөг хүртэл МУИС-ийг 427, Намын дээд сургуулийг 150, Марксизм - Ленинизмийн оройн их сургуулийг 175 нийтдээ дээрх гурван сургуулийг 752 хүн төгссөн байна. Өнөөдөр манай улсад урт богино хугацаагаар сэтгүүл зүйн сургалт явуулдаг газар 10 гаруй байгаа бөгөөд тэдгээрийг төгссөн мэргэжилтнүүдийг оролцуулан тооцоход дотоодын их, дээд сургуулиар 1000 гаруй сэтгүүлч бэлтгэгдсэн байна”¹². 1999 онд МУИС-ийн сэтгүүл

¹² Сэтгүүл зүйн сургалтын өнөөгийн байдал, хэтийн төлөв судалгааны тойм. УБ., 1999

зүйн тэнхимийн багш нарын багийн хийсэн судалгаагаар сэтгүүл зүйн сургалт явуулдаг их дээд сургуулийн тоо 10 гаруй байна гэж гарсан бол 2006 оны байдлаар хоёр дахин өсжээ. Харин эдгээр сургуульд сургалтын программын дагуу эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хичээл орж байгаа нь цөөхөн буюу албан бус судалгаагаар арав дотор тоологдохгүй хэмжээтэй байна. Энэ нь олон шалтгаантай бөгөөд нэгдүгээрт, эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь онолын хувьд төдийлөн хөгжөөгүй, энэ чиглэлийн гарын авлага болох ном, товхимол монгол хэл дээр цөөн хэвлэгдсэн, хоёрдугаарт, багш нарын сэтгүүл зүйн практик болон гадаад хэлний мэдлэг дутмагаас орос, англи хэл дээрх номыг ашиглах боломж хязгаарлагдмал, гуравдугаарт, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үлгэр жишээ нийтлэл ховор буюу жишээлэн үзүүлэх бүтээл хомс, дөрөвдүгээрт, багшлах боловсон хүчин нь оюутан байхдаа энэ чиглэлийн онолын мэдлэг тун бага эзэмшсэн, мөн төгсөөд сэтгүүлчийн ажил хийж байгаагүйгээс практикийн хувьд ядмаг, тавдугаарт, багш нарыг мэргэжлийн хувьд системтэйгээр, ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр давтан сургаагүй зэрэг бодит шалтгаан байна. Эдгээр бодит шалтгаан нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд ямар нэгэн хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, бакалаврын зэрэгтэй, сэтгүүлч мэргэжилтэй оюутан сургууль төгсөхдөө эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр онолын тун бага мэдлэгтэй, практикийн хувьд бараг хоосон төгсөж байгаа нь тухайн хүн энэ чиглэлээр ажиллахад бэлтгэгдээгүй байна гэсэн үг.

Үүний зэрэгцээ сургууль төгсөөд гарсан сэтгүүлчдийг давтан сургах үйл ажиллагааг зохион байгуулахаар үндсэн дүрмэндээ заасан МСНЭ, МСоХ гээд мэргэжлийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд энэ талаар идэвх санаачилгагүй ажиллаж байна. МУҮИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимээс хийсэн нэгэн судалгаанд “Давтан сургалтын асуудлыг сэтгүүлч болгон чухалд тооцдогийг бид судалгааныхаа явцад тогтоосон юм. Харамсалтай нь давтан сургалтад хамрагдсан сэтгүүлч тун цөөхөн (28%) байдаг ажээ. Давтан сургалт ямар чиглэлээр зохиогдвол та оролцох вэ? асуултад төгсөгчид нийт 16 хичээлийн нэр зааснаас хамгийн олон саналыг гадаад хэл(39 %), эдийн засгийн мэдлэг (10.2%), сэтгүүл зүйн онолын шинэ хандлага (9.3%), реклам сурталчилгаа (8.3%), хуулийн мэдлэг (8.3%), компьютерийн гүнзгийрүүлсэн мэдлэг (7.4%) хичээлүүд авлаа” гэж дурьдсан байдаг.

Энэхүү бодлогын судалгааны явцад сэтгүүлчид болон экспертүүдээс авсан ярилцлагын дүнг нэгтгэж үзэхэд тэдний 80 гаруй хувь нь эрэн сурвалжлах чиглэлээр давтан сургалтад хамрагдаж, онолын мэдлэг болон ур чадвараа ахиулахыг чухалчилжээ. Сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх ажлыг олон улсын байгууллагууд, тухайлбал

БАРИМТ 4. *Сэтгүүлч боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээр нь өсгөх үүрэгтэй сэтгүүлчдийн байгууллагуудын ажил үндсэндээ унтарсан гэж болохоор байна. МСНЭ, Спортын сэтгүүлчдийн холбоо зэрэг хэд хэдэн байгууллагын баримт бичигт сэтгүүл зүйг хөгжүүлэх, сэтгүүлчдийн мэргэжил боловсрол, ур чадварыг ахиулах үүрэг тусгагдсан байдаг боловч энэ нь зөвхөн цаасан дээрх тунхаг болж үлджээ.*

Эх сурвалж: МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхимийн судлаач багш нарын хийсэн судалгаанаас

НҮБХХ, Нээлттэй Нийгэм Форум төрийн бус байгууллага, Дэлхийн Банк, Филиппиний Эрэн сурвалжлах сэтгүүл зүй төв, Данийн их сургууль, Хэвлэлийн Хүрээлэн төрийн бус байгууллага, “Зориг” сан төрийн бус байгууллага зэрэг нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр сэтгүүлчид болон сэтгүүл зүйн чиглэлийн багш нарт сургалт явуулж, семинар, уулзалт, ярилцлага зохион байгуулж байгаа нь үр дүнгээ өгч байна. Мөн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлийн онол, практик, арга зүйн ач холбогдол бүхий номууд ч хэвлэгдэн гарч байна.

Дээрхээс үзэхэд Их, Дээд сургуулийн сэтгүүл зүйн ангийн хичээлийн программд “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй” хичээлийг суулгаж, улмаар сэтгүүлчдийг, багш нарыг ч энэ чиглэлээр давтан сургах шаардлага байгаа нь харагдаж байна. Харин энэхүү хэрэгцээ шаардлагыг хангахаар сэтгүүл зүйн мэргэжлийн байгууллагууд бус олон улсын байгууллага, төрийн бус байгууллагууд идэвхтэй ажиллаж байна.

ТАВ. ДЭВШҮҮЛЖ БУЙ БОДЛОГЫН ХУВИЛБАР: ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧИН БОЛОН БИЕ ДААСАН ХАРААТ БУС БҮТЭЦ

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг шинжилж үзсэний үндсэн дээр, мөн гадаад улс оронд энэхүү сэтгүүл зүйгээр дагнасан сэтгүүлчид хэрхэн ажилладгийг судалсны явцад өнөөгийн нөхцөлд эрэн сурвалжлах хүсэл эрмэлзлэл бүхий сэтгүүлчдийг нэгтгэсэн, хараат бус бие даасан бүтэц бий болгох нь зүйтэй гэсэн асуудлыг дэвшүүлэн тавьж байна. Энэхүү бүтэц нь бусад улс орнуудад сэтгүүлчийн өөрсдийнх нь үүсгэл санаачилгаар ажилладаг клубын хэлбэртэй байдаг нь манай орны нөхцөлд мөн тохирох хувилбар гэж судлаач дүгнэлээ. Энэхүү хараат бус бүтэц буюу клуб нь нэг талаасаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр ажиллах сонирхолтой сэтгүүлчдийн нэгтгэн тэдний эрх зүйн хамгааллыг баталгаажуулах чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хараат бус санхүүжилтийг хангах тал дээр олон улсын болон төрийн бус байгууллагуудтай нэгдэн ажиллах уян хатан байдлыг хангахын зэрэгцээ нөгөө талаасаа сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйг таниулах, сахиулах үүрэг бүхий хэвлэлийн өөрийн зохицуулалтын механизмын үүргийг гүйцэтгэх боломжтой юм.

Хууль эрх зүйн орчинг сайжруулаагүй нөхцөлд бие даасан бүтэц бий болгоод ажиллахад сэтгүүлчдэд бэрхшээл учрах болно. Одоогийн байдлаар сэтгүүлчдийн хэвлэн нийтэлсэн материалаас үүдэлтэй маргааныг Эрүүгийн хуулийн зүйл ангиар бус хоёр иргэний хооронд үүссэн маргаан гэж үзэн Иргэний хуулиар зохицуулах чиглэлээр асуудал дэвшүүлэн ажиллаж тодорхой амжилтад хүрч байгаа төрийн бус байгууллага, хуульчид, сэтгүүлчид байгаа. Эдгээр хүмүүс, байгууллага нь бие биенээ нөхөн гүйцэлдүүлэх, тухайлбал, сэтгүүл зүйн мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг хувь эрх зүйн мэдлэгтэй хослуулах боломжийг олгож байна. Улмаар энэ хоёр чиглэлийг сэтгүүлчдийн юмуу хуульчдын нэг байгууллага гүйцэтгэхэд хүндрэлтэй тул тодорхой асуудлууд дээр нэгдэн ажилладаг одоогийн уян хатан бүтэц нь клубийн зохион байгуулалтад нийцэж байна.

Нөгөө талаасаа хараат бус клубын зарчмаар ажиллахад аливаа нэг сонин, телевизийн эздийн нөлөөлөл багасаж, сайн дураараа нэгдэн эвссэн

сэтгүүлчдийн хамтын шийдвэрээр редакцийн бодлогыг тодорхойлох боломж гарч ирнэ. Нэгэнтээ энэхүү хараат бус бүтэц нь тодорхой сонин, телевизийн эзэнтэй холбоогүй, гагцхүү сэтгүүлчдийн хамтын шийдвэрээр үйл ажиллагааг явуулдаг уян хатан бүтэцтэй клубын бодлогоор тодорхойлогдох тул хараат бус санхүүжилтийг төсөл, хөтөлбөр хэлбэрээр олох боломж нэмэгдэнэ гэж найдаж байна.

Нэгэнт тодорхой сонин, телевизийн эзний нөлөөлөлгүй хамтын шийдвэрээр үйл ажиллагаагаа зохион байгуулдаг бүтэц бий болсон тохиолдолд хэвлэлийн өөрийн зохицуулалтын механизмын чиг үүргийг энэхүү бүтэц давхар хэрэгжүүлэх боломжтой. Хэн нэгэн эзнээс хараат бус сэтгүүлчдийн клуб нь ёс зүйн дүрмийг баталж, түүнийхээ дагуу сэтгүүлчдийн үйл ажиллагаанд эрүүгийн бус мэргэжлийн хяналт тавих боломжтой юм. Клуб нь ёс зүйн дүрмээ сурталчлах ажил хийх, нотолгоогүй юмуу хэн нэгний захиалгаар мэдээ материал нийтлүүлэхээс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг ажлыг сэтгүүлчдийн дунд хийх, ийм материал нийтлүүлсэн сэтгүүлчдэд мэргэжлийн үүднээс сахилгын сануулга өгөх, мөн ийм хэрэг үйлдсэн хэмээн буруутгагдаж байгаа сэтгүүлчдэд хууль зүйн хамгаалалт үзүүлэх чиг үүргийг давхар гүйцэтгэх боломжтой юм. Энэ ажилдаа клуб нь хуульч, өмгөөлөгчдийн хүчийг дайчлан ажиллах уян хатан бөгөөд цэвэр мэргэжлийн бүтэц байх болно.

5.1. ЭРЭН СУРВАЛЖЛАХ БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БҮТЭЦ, БУСДЫН ТУРШЛАГА

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хараат бус, бие даасан бүтэц нь бусад орны жишгээс үзэхэд эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр мэргэшсэн сэтгүүлчдээс бүрддэг мэргэжлийн институц юм. Тус институцийн гол үүрэг нь ардчиллын үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэхэд оршино. Монголын нийгмийн одоогийн нөхцөл байдал болоод олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлын хойноос эрэн сурвалжилсан мэдээ, мэдээлэл түгээхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Мөн ямар нэгэн бие даасан сонин сэтгүүл, радио телевизийн ажлыг орлох бус зөвхөн Монголын хэвлэл мэдээллийн салбарт ёс зүйн баримтлалыг бэхжүүлэх, мэргэжлийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхийн төлөө ажиллана. Жишээ болгож Филиппиний эрэн сурвалжлах сэтгүүл зүйн агентлагийн үйл ажиллагааны талаар өгүүлэхэд, 1997 онд 4 сэтгүүлч эмэгтэй тухайн үеийн Ерөнхийлөгч Жозеф Эстрадагийн орд харш хэрхэн баригдсан талаар эрэн сурвалжилж ихээхэн дуулиан тарьжээ. Тэд ердийн, олон нийтийн хүртээл болсон хэдэн зуун баримт бичгийг сайтар судалсны дүнд

“Ерөнхийлөгч ихээхэн хэмжээний авилга авдаг байсныг илрүүлсэн”¹³ нь хэвлэл мэдээлэл асар их үүрэг, хариуцлагатай байдгийг нийгэмд мэдрүүлж, олон түмэн хэвлэл мэдээллийг дөрөв дэх засаглалын хэмжээнд хүлээн зөвшөөрөхөд ихээхэн түлхэц өгсөн байна. Шүүмжлэхээс ямагт цэрвэдэг байсан Филиппиний хэвлэл мэдээллийн хэрэгсэл хөдөлгөөнд орж, өмнө нь Ерөнхийлөгчид тал заслаа хэмээн шүүмжлэгддэг байсан хэвлэлүүд зориг орж, Ерөнхийлөгч болон түүний тойрон хүрээлэгчидтэй холбоотой бичиг баримтад судалгаа, шинжилгээ хийж, эрэн сурвалжилсан нийтлэлүүд гаргах болжээ. Мөн сэтгүүлчдийн эрэн сурвалжилсан бүтээл нь маш их эрх мэдэл, мөнгө хөрөнгийг өөртөө хуримтлуулж чадсан хүчирхэг Ерөнхийлөгчийн эсрэг шүүх хэрхэн шударгаар ажиллахыг олон түмэн харж, хяналтаа тогтооход ихээхэн тус үзүүлсний зэрэгцээ ард түмэнд удирдагчдыг сонгож чаддаг бас хариуцлага алдвал эргүүлэн огцруулж чаддаг өөрсдийнх нь хүч чадлыг мэдрүүлж өгчээ.

БАРИМТ 5. *Энэхүү хэргийн судалгаа нь тэвчээртэй, тууштай эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь хуулийн хэрэгжилт сул дорой, авилгад идэгдсэн, танил талын харилцаа дэндүү хөгжссөн нийгэмд хүртэл асар их нөлөө үзүүлж чадах юм гэдгийг харууллаа*

Эх сурвалж: Ларс Мюллер, Жэк Жэксон. “Филиппиний Эрэн сурвалжлах төвөөс Дэлхийн банкны тусламжтайгаар хийсэн судалгаа”

Тус агентлаг дэргэдээ хуулийн зөвлөхүүд ажиллуулдаг. Мөн эрэн сурвалжлага хийх явцдаа хөндлөнгийн мэргэжилтнүүдийн мэдлэг боловсрол, шударга, тууштай зан чанарт их түшиглэдэг. Мэдээллийн баттай эх сурвалжийг нууцлах, хамгаалахын төлөө тууштай ажиллаж чаддаг. Баримтуудын хоорондын логик холбоог чухалчлан, эрэн сурвалжилсан материалаа нотлох баримтад түшиглэн олонд хүргэхдээ сэтгүүлчдийн бичлэгийн ур чадварыг чухалчилдаг зэрэг нь тэднийг ихээхэн амжилтад хүргэж чаджээ.

Бидний хөрш, пост коммунист орнуудын нэг ОХУ-ын сэтгүүлчдийн эрэн сурвалжлах арга туршлагаас үзэхэд чөлөөт сэтгүүлчдийг нэгтгэсэн эрэн сурвалжлах хувийн агентлаг тэнд ажиллаж байна. ОХУ-д гол гол хэвлэл улс төрийн капитал буюу улс төрчдийн засгийн төлөөх тэмцлийн зэвсэг болон илүүтэй ашиглагдаж байгаа өнөө үед Санкт-Петербургийн

¹³ www.pcij.org

шинэ үеийн хэсэг сэтгүүлчид Андрей Константинов хэмээх үзэг нэгт нөхрийнхөө үүсгэл санаачилгыг дэмжин тус агентлагаа байгуулжээ. Агентлагт 40 гаруй сэтгүүлч, цөөн тооны хуульчид ажилладаг. Харьяаллын хувьд улс төр, бизнесийн бүлэглэлээс хараат бус ажилладаг тус агентлаг Төрийн Думын гишүүн байгаад гэнэт егүүтгэгдсэн эмэгтэйн үхлийн шалтгаанаас эхлээд хэдэн тэрбум ам.долларын зээл авсан ч үйл ажиллагаа нь дампуурсан барилгын компанийн сүйрлийг мөшгин сурвалжилж олны хүртээл болгожээ. Тус агентлаг 24 цагаар мэдээлэл авах утас ажиллуулж, эрэн сурвалжлах шаардлагатай гэж үзсэн баримт, хэрэг явдал, зөрчлийн хойноос нэг биш баг сэтгүүлч томилон явуулж, үр дүнг нь үзэхийг зорьдог ажээ. Тэд эрэн сурвалжлага хийх явцдаа шударга ёс, сэтгүүлчийн ёс зүй, нийгмийн, нийтийн ашиг сонирхлыг эрхэмлэхийг хичээдэг бөгөөд мэдээллийн баттай эх сурвалжийг урьдчилан тохирсон л бол ямар ч нөхцөлд нууцлах ёстой гэдэг зарчмыг хатуу баримтлан ажилладаг аж. Орост мэдээлэл олж авах хууль зүйн бололцоо өмнөх үеэс хавьгүй хялбар болсон ч сэтгүүлчдийн хувьд төрийн эрх баригчдын болон бизнесийн хүрээнийхний үйл ажиллагаа ил тод бус хаалттай бүс хэвээр байгаа аж. Орост эрэн сурвалжлага хийнэ гэдэг албан ёсны эрх баригчдын эсрэг нүцгэн гараар үзэлцэхтэй адил гэж сэтгүүлчид дүгнэдэг ч А.Константиновын агентлаг орчин үеийн эрэн сурвалжлах үйл ажиллагаанд дэвшил авчирч, хэвлэлүүдэд нөлөөлөх болсныг хүлээн зөвшөөрдөг байна. Андрей Константиновын агентлагт Финлянд, Шведээс ч тодорхой хэрэг явдлын зангилааг мөшгин илчлүүлэх захиалга ирж байсан гэдэг. Улс төр, бизнесийн хаагдмал орчин, хууль эрх зүйн төгс бус зохицуулалтын дунд ажиллаж байгаа Оросын сэтгүүлчид эрэн сурвалжлах агентлаг байгуулан ажиллаж байгаа нь Монголын сэтгүүлчдэд практик арга зүй болно.

БАРИМТ 6. *Оросын сэтгүүл зүйд эрэн сурвалжлагын хэлбэр социализмын үед ч байсан, гэхдээ тухайн үеийн сониньхон мэргэжлээ богино хугацаанд сольж үйлчлэгч, таксины жолооч мэтийг хийж үйлчилгээний байгууллагуудын ажлын дутагдлыг шүүмжлэхээс хэтрээгүй бол шинэ үеийн сэтгүүлчид тун тааламжгүй орчинд эрх мэдэлтнүүдийн нийгмээс нууцалж байгаа зарим үзэгдлийн мөн чанарыг илрүүлж чаддаг болсон нь ахиц дэвшил гэж Санкт-Петербургийн Их сургуулийн доцент АА. Юрков үзэж байна.*

Эх сурвалж: Ц.Ганболд “Цагаан шөнийн бүдгэр таталбар”. “Өдрийн сонин”. 2002. №197

АНУ-ын сэтгүүлчдийн зарим туршлага, арга зүйгээс цөөн зүйлийг дурьдахад Калифорни мужийн Сан-Франциско хотноо 1974 онд хэсэг сэтгүүлчид сэтгүүл гаргах санаа дэвшүүлж, дараа онд нь өөр хэсэг хүмүүс Үндэсний дэвшлийн төлөө хэмээх ашгийн төлөө бус сан байгуулжээ. Удалгүй тэд “The Foundation for National Progress” сан дор нэгджээ. Тэгээд аль нэг том компани, корпорацид харьяалагддаггүй “Mother Jones” бие даасан сэтгүүлээ гаргаж, түүндээ эрэн сурвалжилсан нийтлэл дагнан хэвлэх болжээ. Сэтгүүлийг захиалсан хүн бүр шууд тус сангийн гишүүн болдог учраас эрх ашгийг харилцан тэнцвэржүүлсэн ардчилсан зарчим тэнд үйлчилдэг байна. Санхүүжилт нь уншигчдаас өгдөг хандив бөгөөд тэдгээрийг сэтгүүлийн дэргэдэх Эрэн сурвалжлах сангийн нэрээр авдаг. Хандив өргөсөн хүмүүсээ өгсөн хэмжээтэй нь нийтэд мэдээлдэг. Харин хандив өргөсөн сангийн зөвхөн нэрийг л нийтэд түгээдэг аж. Үндэсний дэвшлийн төлөө сангийн санхүүжилт болон хөндлөнгийн хандивынхаа тусаар сэтгүүл бие даасан байр суурьтай байж чаддаг бөгөөд ашгийн төлөө бус статустай учраас татвар төлдөггүй, шуудангийн зардлаа ч хөнгөлүүлдэг аж. Эрэн сурвалжилсан нийтлэлүүд уйгагүй ажиллагаа, багагүй цаг хугацаа зарцуулдаг учраас сэтгүүл нь хоёр сар тутамд нэг дугаар гардаг. Мөн “Mother Jones” сэтгүүл Интернэтэд сайтаа нээж нийтлэлүүдээ бүгдийг оруулсан нь олон сая хүний хэрэгцээт вэб болжээ. Энэ сангийн болон сэтгүүлийн арга ажиллагаа нь манайд хэрэгжүүлж болохуйц санагдана.

БАРИМТ 7. *Сэтгүүл үүссэн 1970-аад оны дунд үеийн Америкийг эргэн санавал, иргэний эрхийн хөдөлгөөн нүргэлж, Америкийн цэрэг Вьетнамыг орхиж, 1974 оны эхээр “Вашингтон Пост” сонины овсгоотой хоёр сэтгүүлч Уотергейтийн хэрэг явдлыг илчилж, улмаар намар нь Ерөнхийлөгч Никсон огцроход хүрч хэвлэл мэдээлэл ямар хүчтэйгээ харуулсан цаг үе байлаа. Яг энэ үед бие даасан шинэ хэвлэлүүд олноор төрсний нэг нь “Mother Jones” сэтгүүл юм. Үүнээс өмнө Америкийн эрэн сурвалжлах сэтгүүл зүй улс төрчид рүү онилсон байв. Тэгвэл “Mother Jones” зах зээлийн нийгмийн сонгогдоогүй засаглал болох үндэстэн дамнасан корпорациудыг анх удаа овоо хараандаа авчээ. “Бид том корпорациудыг хянадаг хоточ нохой юм” гэж сэтгүүлийн эрхлэгч Ричард Рейнольдс тодорхойлов*

Эх сурвалж: Д.Цэрэнжав. “Эрэн сурвалжлагын сэтгүүл”. “Монголын ОНМХ-ийн тойм”, 2001 он, No9-10

Мөн Шведэд мөн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бие даасан институт ажилладаг бөгөөд тэр эрэн сурвалжлага хийхийн зэрэгцээ сэтгүүлчдээ сургах, орчин үеийн эрэн сурвалжлагын арга болох CAR computer assistant reporting аргыг дэлгэрүүлэн амжилттай ажиллаж байна. Азид Хонг Конгийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн байгууллага бас нилээд сайн ажилладаг. Эрэн сурвалжлагчид Авилгын эсрэг хараат бус байгууллагадаа нилээд дэмжлэг үзүүлдэг бөгөөд шударга бус үйлдлийн эсрэг хоёр байгууллага хүч хавсран тэмцэх ч тохиолдол гардаг байна. Энэ мэтчилэн дэлхийн олон оронд бидэнд арга туршлага болохуйц Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бие даасан исэлдэцгээ бишгүй байна.

Дээрх жишээнүүдээс үзэхэд, Монголд эрэн сурвалжлах сэтгүүлчдийн эрх зүйн хамгаалалтыг хангаж өгөхийн зэрэгцээ мэргэжлийн ёс зүйн сахиулах, тэдний мэргэжлийн чадавхийг хөгжүүлэх хараат бус, бие даасан бүтэц бий болбол энэ сэтгүүл зүй хөгжих боломж харагдаж байна. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтцийн “бие даасан, хараат бус” гэдэг үгийн агуулгыг ч бусад орны жишээнээс тодорхой харж болохоор байна. Үүрэг, зорилгын хувьд энэхүү бүтэц нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх замаар албан тушаалтнуудын хаацайлан далдлахыг хүсэж байгаа нууцлаг зүйлийг ил гаргаж тавих, далд сэдвийг дэлгэсний дүнд олон түмний анхаарлыг уг асуудалд хандуулж, улмаар тэдний хяналтыг бий болгох, нийгмийн шударга бус тогтолцоог өөрчлөхөд иргэдийн оролцоо чухал байгааг олон түмэнд мэдрүүлж, сайн засаглал бүрдүүлэхийн төлөө хэвлэлийн мэдээллийн дөрөв дэх засаглалын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Харьяаллын хувьд төр, улс төрийн хүчин, бүлэглэл, холбоо, хөдөлгөөнөөс хараат бус ажилладаг уян хатан бүтэц байх юм. Санхүүжилтийн хувьд мөн дээрх субъектүүдээс ангид, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн бие даасан зарчмаар ажиллана. Хамгийн гол нь эрэн сурвалжлах сэтгүүлчдийн өөрсдийнх нь үүсгэл санаачилгаар бий болсноор хараат бус санхүүжилтийг татах боломж нь нэмэгдэнэ.

Клуб нь сэтгүүлчдийн өөрсдийн үүсгэл санаачилгын бүтэц байх учраас онолын болон практикийн туршлага хуримтлуулсан удирдлагаа өөрөө дэвшүүлэх, сонгох, солих боломжтой болно. Энэ зарчмаар ажилласан тохиолдолд тэдний эрэн сурвалжилсан нийтлэлийг хэн худалдан авч нийтлэх вэ? Бүтээгдэхүүнээ хэрхэн нийгэмд хүргэх вэ? гэдэг асуудал тулгарна. Улс төр, санхүүгийн бүлэглэлээс хараат ажиллаж буй томоохон хэвлэлийн мэдээллийн хэрэгслийн ашиг сонирхолд нийцэхгүй гэдэг нь тодорхой. Тэгвэл хэрхэн яаж санхүүжих вэ гэсэн асуудалд мэргэжилтнүүд “Монголд ардчилсан, ил тод, шударга нийгмийг тогтоохын төлөө хөтөлбөр, төслөө хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагаас эдийн

засгийн дэмжлэг авч хөгжих нь хамгийн зөв хувилбар” гэдэг саналыг дэвшүүлж байгаа юм. Монголын ардчиллыг дэмжих, ардчилсан хэвлэл мэдээллийг хөгжүүлж төлөвшүүлэхийн төлөө олон улсын байгууллагууд ихээхэн хөрөнгө оруулалт хийж байгаагаас харахад мэргэжилтнүүдийн дэвшүүлж буй санал бодол нь биелэгдэх магадлалтай хувилбар билээ.

5.2. БИЕ ДААСАН, ХАРААТ БУС ИНСТИТУЦИЙН ҮҮРЭГ, БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх, улс төр, эдийн засгийн бүлэглэлээс хараат бус удирдлагаа клуб өөрөө үүсгэн бүрдүүлэх ба энэ нь зөвлөлийн хэлбэртэй байхад тохиромжтой. Зөвлөлийн бүрэлдэхүүн тодорхой шалгууруудын дагуу нэр дэвшүүлж томилох бөгөөд шалгууруудын олон улсын туршлага, өөрийн орны онцлогт нийцүүлэн клубын гишүүд өөрсдөө гаргаж ирэх нь зүйтэй. Эдгээрийн дотор жишээлбэл, төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан, бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажиллаж байгаа, түүнчлэн ажилладаггүй боловч хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход нь оролцогч, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөрөнгө оруулагч нь ашиг сонирхлын зөрчлийн улмаас удирдах бүрэлдэхүүнд орохгүй гэдгийг тодорхой заах нь зөв юм. Клубын дээд удирдах байгууллага болох Зөвлөл нь ёс зүйн дүрмийг сахиулах, болон хамгаалалт, бодлогоо тодорхойлох юм. Филиппинд Зөвлөхүүдийн зөвлөл нэртэй хараат бус, үнэнч шударга, бие даасан байдлаараа сонгогдсон хүмүүсээс бүрдсэн баг ажилладаг бөгөөд тэд төвийн үйл ажиллагааны стратеги, тактикийг боловсруулахад тусалдаг байна. Өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, захиргааны ажлыг удирдан явуулах чиг үүргийг гүйцэтгэх менежментийн баг байдаг нь олон улсын байгууллагуудын бүтцээс харагдаж байна. Энэ нь редакцийн зөвлөлийн хэлбэрээр ажиллаж болох бөгөөд агентлагийнхаа үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг хэлэлцэн зохион байгуулан үүрэгтэй ажиллах юм. Мөн клуб нь мөрдөгдөж буй хууль, журмын хүрээнд ажиллах, эрх зүйн хүрээг эрэн сурвалжлах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр боловсронгуй болгоход хуулийн зөвлөгөө өгөх хуулийн зөвлөх дэргэдээ ажиллуулдаг байна. Хуулийн зөвлөх нь сэтгүүлчдийг эрэн сурвалжлах явцдаа хууль зөрчсөн үйлдэл хийхээс хамгаална. Омбудсмэн буюу уншигчдын өмгөөлөгч дэргэдээ ажиллуулах бөгөөд энэ нь тухайн байгууллагын өөртөө шүүмжлэлтэй буюу хариуцлагатай байхын баталгаа болдог. Омбудсмэн нь тухайн байгууллагын гишүүн байх бөгөөд уншигчдын гомдол, санал бодол, сонирхсон зүйлийг лавлаж, тэднээс мэдээлэл авч, тэдгээрийг хэрэгжүүлэх эрхийг уншигчдад олгодог.

Клубын санхүүжилт ямар эх сурвалжаас хангагдах нь анхаарал татсан асуудал бөгөөд хараат бус байхын тулд юуны өмнө Монголын ардчилал, сайн засаглалыг дэмжин хөтөлбөр, төслөө хэрэгжүүлдэг олон улсын байгууллагын дэмжлэгийг тодорхой хугацаанд авч ажиллах боломжтой. Үүний зэрэгцээ дэргэдээ “Эрэн сурвалжлах сан” байгуулж, хөндлөнгийн хандиваар үйл ажиллагаа явуулах боломж харагдаж байна. Харин хандивлагчаа Америкийн “Mother Jones” сэтгүүлийн жишгээр ил тод мэдээлдэг зарчимтай байх нь хараат бус ажиллаж байгааг баталгаажуулах нөхцөл болох юм.

Цаашдаа клуб нь бие даасан сэтгүүл эсвэл сонин гаргаж захиалга авдаг болж, энэ эх сурвалжаас санхүүжилтээ голлон бүрдүүлэх чиглэлийн барьж ажиллах боломжтой, Сонин, сэтгүүлийн уншигч, захиалагчийн хандив нь ч санхүүжилтийн нэг хэлбэр байхаар зохион байгуулж болно. Гэхдээ энэ нь цаг хугацааны хувьд хурдан биелэх боломжгүй бөгөөд олон нийтийн итгэлд тулгуурласан боломж учраас итгэлийг нь олж авсан үед тэднээс ирэх хандив нэг төрлийн санхүүжилт болно.

Үүний зэрэгцээ тус бүтэц нь сэтгүүлчдийн эрэн сурвалжлах онол, арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулж, энэ чиглэлийн олон улсын болон дотоодын сургалтын байгууллагуудтай холбоо тогтоон ажиллах үүргийг хүлээвэл зохино. Бусдын туршлагаас харахад сургалт, судалгаа нь ийм төрлийн байгууллагын үйл ажиллагааны нэг чиглэл төдийгүй санхүүжилтийн бас нэг эх үүсвэр нь болдог ажээ.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн явц, түүний хөгжилд учирч буй саад бэрхшээлийг судалж, нэгтгэсний үндсэн дээр дүгнэхэд хууль эрх зүйн орчинг сайжруулах, редакцийн хараат бус байдлыг бий болгох нь зайлшгүй шаардлагатай ч тэрхүү өөрчлөлт нь цаг хугацаа болон үйлдэл, хүсэл эрмэлзлийн хувьд сэтгүүлчдээс хамаарахгүй зүйлс учраас өнөөдөр энэхүү сэтгүүл зүйг хөгжүүлэх хамгийн боломжит хувилбар нь энэхүү бие даасан бүтэц гэж үзэх үндэстэй юм. Түүний хэлбэр нь судлаачийн санал болгосон клуб гэсэн хэлбэрт баригдахгүйгээр үйл ажиллагааны гол зарчим, арга барилд түшиглэсэн ямар ч институци байж болно

ЗУРГАА. Дүгнэлт

Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд саад болж байгаа эрх зүйн гадаад орчны хүчин зүйлсийн зэрэгцээ сэтгүүл зүйн салбарын дотоод гэж нэрлэж болох хүчин зүйлс мөн нөлөөлж байгаа нь энэ судалгаанаас харагдлаа. Эдгээрийг тоймлон дүгнэвэл:

6.1. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Нэгдүгээрт, Монгол улсад өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиуд нь чөлөөт хэвлэл болон түүний хүчтэй илрэл болсон эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр дагнан ажиллахад ихээхэн саад дарамт учруулж байна. Нэг ёсондоо хуулиар дамжин хэрэгждэг төрийн цензур өнөөдөр хүчтэй байна. Үүнд юуны өмнө Эрүүгийн хуулин дахь Доромжлол, Гүтгэлэгтэй холбоотой заалт нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд шууд хаалт болохоор заалт болж байгааг онцлох хэрэгтэй. Улс төрчид, эрх баригчид, төрийн албан тушаалтнууд уг заалтыг цензур болгон хэрэглэж, өөрийнх нь тухай шүүмжлэлтэй нийтлэл гарах бүрт шахам гүтгэгдсэн, доромжлогдсон гэсэн үндэслэлээр сэтгүүлчийн эсрэг нэхэмжлэл гаргадаг жишиг тогтоод байна. Энэ нь хэвлэл мэдээлэлд үзүүлэх шахалт болж, түүний хэрээр төрийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих сэтгүүл зүйн үйл ажиллагаанд саад тотгор болж байна. Иймд “Үнэхээр буруутай, хэн нэгнийг гүтгэсэн, худал зүйл бичсэн бол хариуцлага хүлээх нь зүйн хэрэг. Гэхдээ энэ нь Иргэний хуулиар зохицуулагдах ёстой” гэж ихэнхи сэтгүүлч үзэж байна. Тэдний энэхүү саналтай мэргэжилтнүүдийн байр суурь ч нэгдэж байгаа юм. Гэхдээ энд үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөтэй холбоо бүхий бас нэг анхаарах зүйл байгаа нь Иргэний хуульд ч зохих хязгаарлалт хийх тухай асуудал юм. Иргэний хуулиар ихэвчлэн нэр төр гутаах тухай асуудал хөндөгддөг. Иргэний хуулийн нэр төр гутаахын эсрэг заалт нь олон улсын хууль тогтоомжийн жишигт нийцсэн байх шаардлагатай байна. Тухайлбал, төр, төрийн байгууллага, төрийн бүх төрлийн албан тушаалтнууд нэр төр гутаасан тухай хэрэг үүсгэх эрхгүй байх, төрийн зүтгэлтнүүд иргэдтэй харьцуулахад илүү их шүүмжлэлийг хүлээн зөвшөөрдөг, тэвчдэг байх зарчмыг тусгах, үнэн зөв нь ямагт өмгөөлөх хэрэгсэл байх, нэхэмжлэгч олон нийтийн эрх ашигт хамаарал бүхий үйл явцын баримтын талаар худал гэж үзэж буйгаа нотлох

үүргийг хүлээдэг байх, хэнийг ч үзэл бодлоо илэрхийлсний нь төлөө нэр төр гугаасан хэрэгт хариуцлагад татаж үл болно гэх мэт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах шаардлагатай байна.

Эрх зүйн хүрээнд анхаарах ёстой дараагийн асуудал бол Монголын сэтгүүлчид өнөө хэр төр засгийн байгууллагаас мэдээлэл авч чадахгүй байгаа явдал юм. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаанд ямар нэг шударга бус, хууль ёс зөрчсөн үйлдлийг олж харсан ч араас нь мөрдөн мөшгиж түүнийгээ нотлох хэмжээний мэдээллийг олж авах боломж гардаггүй нь сэтгүүлчдийн мэргэжлийн ажил болон нийгмийн өмнө хүлээсэн “дөрөвдөгч засаглал”-ын чиг үүргийнхээ дагуу иргэд, олон нийтийн эрх ашгийн өмнөөс хяналт тавьж чадахгүйд хүрдэг. Мэдээлэл олж авах эрхийн тухай асуудал нь зөвхөн сэтгүүлчдэд бус бүх иргэнд хамааралтай бөгөөд энэ чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа олон төрийн бус байгууллага (Нээлттэй Нийгэм Форум, Глоб Интернэшнл, Нийгмийг Дэвшил Эмэгтэйчүүд зэрэг)-аас хийсэн тууштай нөлөөллийн ажлын үр дүнд энэ хуулийн төсөл боловсруулагдаад, УИХ-д өргөн баригдаад даруй хэдэн жил болж байна. УИХ-ын 2008 оны хаврын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөгөөнд орсон ч амжилгүй шинэ парламенттай золголоо. Парламентын залшамж бодлого, хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд энэхүү хуулийн төслийг 2008-2012 оны УИХ хэлэлцэн баталвал төрийн байгууллагуудад байгаа мэдээллийг иргэд нээлттэй авах эрхтэй болох, төрийн байгууллага, албан тушаалтан иргэдийн хүссэн мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй болох юм. Нэг ёсондоо Мэдээллийн эрх чөлөөний хууль нь ардчилал бодитой хөгжиж буйн томоохон илрэл билээ.

Гуравдугаарт, дэлхий нийтээр сэтгүүлчийн цорын ганц онцгой эрх гэгддэг эх сурвалжаа нууцлах, хамгаалах эрхээ Монгол сэтгүүлчид эдэлж чадахгүй байна. Эх сурвалжаа нууцлах, хамгаалах эрхийг хуульчлаагүй нь илчлэхийг шаардах шалтгаан болж, улмаар мэдээлэгчийн аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулахад хүргэж байна. Баталгаатай, найдвартай эх сурвалжаас авсан нотолгоо, баримтат мэдээлэл нь эрэн сурвалжлах сэтгүүлчийн хийсэн дүн шинжилгээ, ажиглалтыг баталгаажуулах цорын ганц эх сурвалж болох тохиолдол цөөнгүй байдгийг бид гадаадын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн туршлагаас мэднэ. Тэгэхлээр энэхүү онцгой эрхийг хуульчлах зайлшгүй шаардлагыг сэтгүүлчид хүсч байгаа бөгөөд энэ нь төрийн нээлттэй, ил тод байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн нэг том бодитой алхам болно.

6.2. РЕДАКЦИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

Хэвлэлийн эзэн, редакци нь нийтлэлийн бодлого, эрх ашиг хоёроо зааглаж чадахгүйгээс хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өнөөдөр улс төрийн болон эдийн засгийн бүлэглэлийн эрх мэдэл дор ажиллаж байна. Нэг ёсондоо хэвлэл мэдээлэл нь олон нийтийн эрх ашгийг өөрийн санхүүгийн сонирхол, эздийн хувийн болон улс төрийн сонирхлоос дээгүүр тавьж ажиллаж чадахгүй байна. Ийм нөхцөлд сэтгүүлчид нь төрийн бодлогын болон түүний хэрэгжилтэд хараат бус мониторинг хийгээд, үр дүнг нь олон нийтэд хүргэх боломжгүй болж мэдэх юм. Сэтгүүлчдийн хэлснээр хэвлэлийн эзэн цаг хугацаа, эдийн засаг, хүн хүчний нөөц боломж хомс ч гэдэг юмуу элдэв шалтаг тоочин ажилтныхаа эрэн сурвалжлах зориг хүсэл, ур чадварыг хэзээ ч дэмждэггүйгээр бүр тод илэрч байна. Мөн редакцийн хараат бус байдал нь сэтгүүлчийн өөрийн цензурыг хүчтэй болгож байгаа бөгөөд редакци хуулийн байгууллага болон аливаа нөлөөллийн эсрэг сэтгүүлчээ хамгаалж чадахгүй байгаа нь тэднийг айдас болгоомжлолд хүргэж, улмаар эрэн сурвалжлах зориг хүслийг нь мохоож байна. Энэ талаар сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалсан мэргэжлийн байгууллагууд ч огт дуугарахгүй байна. Зүй нь редакцийн хараат бус байдлыг хуульчлахаасаа илүү хэвлэл мэдээллийн өөрийн дотоод зохицуулалтаар хийж чадвал түүний хараат бус, бие даасан байдал илүү хангагдах учиртай. Редакцийн хараат бус байдлын төлөө сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд ихээхэн санал санаачилга гаргаж ажиллах хэрэгтэй байна. Юуны өмнө МСНЭ, МҮЭ болон хэвлэл, сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллагууд хэвлэл мэдээллийн хэрэгслийн далд эздэд шахалт үзүүлэх, тэдгээрийн нэрийг олон түмэнд ил тод мэдээлэх алхмуудыг хийвэл чөлөөт хэвлэлийн төлөвшилтөд ихээхэн тус дөхөм үзүүлэх болно.

6.3. СЭТГҮҮЛЧИЙН ӨӨРИЙН ЦЕНЗУР

Хууль эрх зүйн төгс бус орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат байдал нь сэтгүүлчдийн өөрийн цензурыг хүчтэй болгож байна. Өөрийн цензур нь сэтгүүлчид нь хуулийн болон редакцийн дарамт шахалтаас болгоомжилж, эрх зүйн хамгаалалтгүй орчинд эрх мэдэлтнүүдийг шүүмжилсэн нийтлэл гаргахаасаа эмээж, улмаар ажлын байр хийгээд амь насанд нь заналхийлэл ирж мэднэ зэрэг үндэслэлээр эрэн сурвалжлага хийхээсээ татгалзан байгаагаар илэрч байна. Сэтгүүлчдийн өөрийн цензур, айдас болгоомжлол нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд саад болж буй бодит хүчин зүйлсийн нэг юм. Өөрийн цензур нь редакцийн хараат бус байдалтай хамгийн их уялдаа холбоотой байдаг. Тогтолцооны

зүгээс энэ асуудлыг авч үзвэл сэтгүүлчийн өөрийн цензур нь сэтгүүлчийг хамгаалах байгууллага, бүтэц байхгүй байгаатай холбоотой гэж дүгнэж болохоор байна. Сэтгүүлчийн хамгаалалт баталгаажуулах нь мэргэжлийн ажилд саад болох бодит нөхцөл болж байгаа тухай сэтгүүлчидтэй хийсэн ярилцлагын үр дүн харуулж байна.

Нөгөө талаар сэтгүүлчдийг эрэн сурвалжлах арга барилд сургах, мэргэшүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна. Сэтгүүл зүйн сургалттай сургуулиудад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, дадлагын хичээл зохих хэмжээнд заагдахгүй байгаагаас энэ талаарх сэтгүүлчдийн мэдлэг тун дулимаг байдаг аж. Онолын дулимаг мэдлэг нь практик дахь эрэн сурвалжлах үр чадварт нөлөөлж байгаа нь судалгаанд оролцсон сэтгүүлчдийн ярилцлагаас илт байна. Сэтгүүлчид эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлийн давтан сургалтад хамрагдах, энэ чиглэлээр мэргэших, бусдын арга зүйгээс суралцахыг чухалчилж байв. Мэргэжилтнүүд ч сэтгүүлчдэд гүнзгийрүүлсэн судалгаа хийх, таамаг дэвшүүлэх, асуудлын баримтыг задлан шинжлэх, нягтлан харьцуулах, баримтын логик холбоог сайтар мэдрэх үр чадвар дутагддагт шүүмжлэлтэй хандаж, тэднийг давтан сургах нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд чухал алхам болно гэдгийг онцолж байв.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд учирч буй эдгээр бодит бэрхшээлийг өөрчлөхөд цаг хугацааны хүчин зүйлээс гадна төрийн бодлого боловсруулагчдын болон хэвлэлийн эздийн, мэргэжлийн байгууллагуудын улс төрийн тууштай хүсэл зориг ихээхэн үүрэг гүйцэтгэнэ.

Редакцийн хараат бус байдлыг баталгаажуулахын хэрэгцээ шаардлагыг олон хүн хүлээн зөвшөөрдөг хэрнээ Эрүүгийн хуулиар шийтгэгддэггүй сэтгүүлчдэд мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг нь хангаад өгөхлөөр баталгаажуулах мэдээллийг найдвартай эх сурвалжаас авсан баталгаат мэдээлэл гэж танилцуулах явдал гарна хэмээн хүмүүс эмээдэг. Гэтэл эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эдгээр зарчим нь дэлхийн олон оронд хуульчлагдан үйлчилж байгаа билээ. Сэтгүүлчдийг худал, баталгаажуулах, захиалгат мэдээлэл нийтлэхээс сэргийлэх зорилгоор Эрүүгийн бус Иргэний хуулийн зохицуулалтыг ашиглахын зэрэгцээ Хэвлэл мэдээллийн өөрийн хяналтын механизм, сэтгүүлчдийн Ёс зүйн дүрэм зэрэг мэргэжлийн хатуу механизмууд үйлчилдэг. Энэ туршлагыг манайд авч хэрэглэх боломжийг манай төрийн бус байгууллагууд хангалттай судалсан учраас одоо улс төрчид, эрх мэдэлтнүүдийн хүсэл зориг л дутаж байна.

Хэвлэл мэдээллийн өөрийн хяналтын механизм, сэтгүүлчдийн Ёс зүйн дүрмийн гүйцэтгэлд хяналт тавихын зэрэгцээ сэтгүүлчдийг хамгаалах, хуулийн зөвлөгөө, мэргэжлийн сургалтаар хангах хараат бус бүтэц

байгуулах хэрэгцээ харагдаж байна. Өнөөдрийн нөхцөлд Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд эрэн сурвалжлах сэтгүүлчдийг нэгтгэсэн хараат бус бүтэц бий болгох нь хэрэгжиж болох хамгийн зөв хувилбар байж болох юм. Бусад орны туршлага, арга зүй ч үүнийг нотолж байгаа билээ. Ялангуяа улс төр, нийгмийн ижил тогтолцоонд байсан пост коммунист орнуудын сэтгүүлчдийн арга барил Монголын мэргэжил нэгт нөхдөд нь ихээхэн дэмжлэг, арга зүй болно. Энэхүү бүтцийг эрэн сурвалжлах сэтгүүлчид өөрсдөө бий болгох бөгөөд гагцхүү хараат бус, бие даасан тогтолцоотой ажиллахад тэдний нэгдмэл байдал, санхүүгийн дэмжлэг ихээхэн ач холбогдолтой юм. Уг бүтэц нь агентлаг, төв, клуб зэрэг янз бүрийн хэлбэртэй байж болох бөгөөд гагцхүү хараат бус нэгдмэл удирдлага, нэгдсэн бодлого, төлөвлөгөө, бие даасан санхүүгийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа нь хэрэгжинэ. Үйл ажиллагаа нь үнэн буюу нотлох баримтад тулгуурласан эрэн сурвалжлах сэтгүүл зүйн жинтэй бүтээл хийж олны хүртээл болгоход оршино. Үүний ачаар юуны өмнө үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрх хангагдаж, улмаар бодит мэдээллийн дүнд хүчирхэгжин, шийдвэр гаргахдаа зөв хандлагатай болж, нийгмийн тогтолцоог эрүүлжүүлнэ. Нөгөө талаар олон түмний итгэлээр эрх мэдэлд хүрсэн төр, төрийн байгууллагын албан тушаалтны үйлдэл илүү хариуцлагатай болж, нийгэмд шударга ёс тогтоход нөлөөлнө. Басхүү хэвлэл мэдээллийн чөлөөт байдал хангагдахад бодитой нөлөө үзүүлж, улмаар хэвлэл мэдээлэл хэрхэн дөрөв дэх засаглалын үүргээ гүйцэтгэж чаддагийн үлгэр жишээ болж, нийт системд нь өөрчлөлт гарахад эерэг нөлөөлөл авчирна. Эцэст нь ардчилал Монголд бодит утгаараа хөгжихөд буюу нийт тогтолцооны хувьд эрүүл, ил тод, хариуцлагатай, иргэн хүний оролцоотой, хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг хангасан нийгмийг бүрдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах болно. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хүч чадал ч үүнд оршдог билээ.

ДОЛОО. Зөвлөмж

Монголд эрэн сурвалжлах сэтгүүл зүйг дэмжих чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах, эрэн сурвалжлах сэтгүүлчдийн үүсгэл санаачилгын хараат бус, бие даасан бүтэц бий болбол энэ сэтгүүл зүй хөгжих боломж харагдаж байна.

1. Эрх зүйн орчинг сайжруулахад чиглэсэн дараах алхмуудыг хууль гаргагч, бодлого боловсруулагчид хандан гаргаж байна. Үүнд:

- 1.1. 2004-2008 оны УИХ-д өргөн баригдаж, хэлэлцэх асуудлын дараалалд орсон Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэ парламент даруй хэлэлцэн батлах. Энэхүү хуульд мэдээ баримт цуглуулах, олж авах нь энэхүү хуулийн амин чухал бүрэлдхүүн гэдгийг хүлээн зөвшөөрч, мэдээлэл авах эрхэд хязгаарлалт тавих шалтгаан нь ардчилсан нийгмийн нөхцөлд олон нийтийн ашиг сонирхолд ноцтой аюул учруулахаас өөр зүйл хамаарахгүй гэдэг зарчмыг удирдлага болгох, төр засгийн байгууллага буюу албан тушаалтнуудын хууль бус үйлдлийг задруулахаас хамгаалахад чиглэсэн хязгаарлалт нь дээрх зарчимд хамаарахгүйг нарийвчлан заах, төрийн албан хаагч мэдээллийг зайлшгүй өгөх үүрэгтэй байж, албан тушаалтны зүгээс мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд хянаж үздэг хараат бус тогтолцоо байх зэрэг асуудлыг хуулийн гол бүрэлдхүүн хэсэг болгох
- 1.2. Мэдээлэл олж авах, мэдээллийг өгөх, түгээх явцад нууц эх сурвалжийг хамгаалах, нууцлахтай холбогдсон заалт энэхүү хуулийн төсөлд огт тусгагдаагүй байгааг анхаарах. Үүнд сэтгүүлчид мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад тэднийг хамгаалах болон улс орон, олон нийтийн эрх ашгийн үүднээс сэтгүүлчдэд мэдээлэл өгсөн нууц эх сурвалжийг хамгаалах тухай асуудал хамаарагдана. Мэдээлэл өгсөн эх сурвалжаа хамгаалах нь сэтгүүлчийн мэргэжлийн онцгой эрх бөгөөд үүнийг гагцхүү хуулиар баталгаажуулах.
- 1.3. Нууц баримт бичиг буюу түүнд агуулагдсан мэдээллийг нийтэлсний төлөө эрүүгийн буюу иргэний хариуцлага хүлээлгэх явдлаас сэтгүүлчид хуулиар хамгаалагдах. Энэ нь үнэнийг мэдэх, улмаар өөрийн сонгогдсон төр засагтаа хяналт тавих гэсэн олон

түмний эрх ашгаас улбаатай гэдгийг шийдвэр гаргагчид хүлээн зөвшөөрөх.

1.4. “Эрүүгийн байцаан шийтгэх тухай Монгол улсын хууль” дахь Гүтгэлэг, Доромжлолтой холбоотой заалтыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг маргаан үүсгэн хэлэлцэх замаар Иргэний байцаан шийтгэх тухай хуулиар зохицуулах. Гүтгэлэгийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл нь сэтгүүлч олон нийтийн санаа бодлыг тусгасан нийтлэлийнхээ төлөө өөрөө эрүүгийн хариуцлага хүлээх ёсгүй, сэтгүүлчийг шийтгэх нь түүний үзэл бодлоо илэрхийлэх, түгээх эрхийг зөрчсөн хэрэг, хүний нэр төр, алдар хүнд нь нийтийн гэхээсээ тухайн хувь этгээдийн асуудал, төрийн албан тушаалтан, нийтэд алдартай хүн нь хувь этгээдээс илүү олон нийтийн анхаарлыг татдаг учраас түүний шүүмжийн хүрээ хязгаар илүү өргөн байх учиртай гэсэн ардчилсан орнуудад хүлээн зөвшөөрөгддөг хэм хэмжээнд тулгуурлан Гүтгэлэг, Доромжлолын заалтыг Эрүүгийн хуулиас хасах.

2. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхийг тулд хараат бус бүтэц байгуулах шаардлагатай байна гэж дүгнэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр дагнан ажиллах сонирхолтой сэтгүүлчид, энэ чиглэлийг дэмжих хүсэлтэй хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлагуудад хандан дараах зөвлөмжийг гаргаж байна.

Судалгаанд оролцсон мэргэжилтнүүдийн ихэнх нь өнөөгийн нөхцөлд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бие даасан бүтцийг бий болгохыг чухалчилж байна. Америк, Скандинавын орнууд, ОХУ, Болгар, Швед, Филиппинд энэ чиглэлийн байгууллагууд ажиллаж ирсэн арвин туршлага, арга зүй бий. Ийм клуб нь нэг талаасаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр ажиллах сонирхолтой сэтгүүлчдийн нэгтгэн тэдний эрх зүйн хамгааллыг баталгаажуулах чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хараат бус санхүүжилтийг хангах тал дээр олон улсын болон төрийн бус байгууллагуудтай нэгдэн ажиллах уян хатан байдлыг хангахын зэрэгцээ нөгөө талаасаа сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйг таниулах, сахиулах үүрэг бүхий хэвлэлийн өөрийн зохицуулалтын механизмын үүргийг гүйцэтгэх боломжтой юм.

Монголд сэтгүүлчдийн ийм клубыг байгуулахад удирдлагын хараат бус байдал, санхүүжилтээ хэрхэн хангах асуудал гарч ирнэ. хэрхэн хадгалахыг бодлогын хэмжээнд гаргаж ирэхийг онцолж байв. Мэргэжилтнүүд энэхүү бүтэц эхний жилүүдэд гагцхүү олон улсын байгууллагын дэмжлэг, санхүүжилтээр үйл ажиллагаа явуулбал илүү хараат бус байж чадна гэж үзэж байна. Бие даасан хараат бус бүтэц

нь үүрэг, хэлбэр, удирдлага, үйл ажиллагаа, үр нөлөөний хувьд дараах хэлбэрээр оршин тогтнож болох юм.

Үүргийн хувьд: Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх замаар албан тушаалтнуудын хаацайлан далдлахыг хүсэж байгаа нууцлаг зүйлийг ил гаргаж тавих, далд сэдвийг дэлгэсний дүнд олон түмний анхаарлыг уг асуудалд хандуулж, улмаар тэдний хяналтыг бий болгох, нийгмийн шударга бус тогтолцоог өөрчлөхөд иргэдийн оролцоо чухал байгааг олон түмэнд мэдрүүлж, сайн засаглал бүрдүүлэхийн төлөө хэвлэлийн мэдээллийн дөрөв дэх засаглалын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Хэлбэрийн хувьд: Клуб хэлбэртэй байх нь тохиромжтой. Клуб нь янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажиллаж байгаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр ажиллах сонирхолтой сэтгүүлчдийг нэгтгэсэн уян хатан бүтэцтэй байх юм.

Харьяаллын хувьд: Улс төр, эдийн засгийн бүлэглэлээс хараат бус ажиллаж байж амжилтайд хүрнэ. Хамгийн гол нь эрэн сурвалжлах сэтгүүлчдийн өөрсдийнх нь үүсгэл санаачилгын институт байх учиртай.

Удирдлагын хувьд: Олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх, улс төр, эдийн засгийн бүлэглэлээс хараат бус, онолын болон практикийн туршлага хуримтлуулсан сэтгүүлч, хуульч, олон нийтийн зүтгэлтэн зэргээс бүрдсэн хараат бус Зөвлөлийн хэлбэр байж болно.

Санхүүжилтийн хувьд: Өөрөө өөрийгөө санхүүжүүлэн бие даасан зарчмаар ажиллана. Эхний үед олон улсын байгууллагын дэмжлэг авч болно. Дараа нь хандив, уншигчийн захиалга, сургалтаас орж ирэх төлбөр зэрэг нь гол санхүүжилт болно. Санхүүжилтээ ил тод мэдээлдэг зарчимтай байвал зохино.

Бүтцийн хувьд: Удирдах зөвлөл, менежментийн баг, редакцийн зөвлөл, сэтгүүлчид, хуульч, омбудсмен зэргээс бүрдэж болно. Эрэн сурвалжлагч сэтгүүлчид, мөрдөгдөж буй хууль, журмын хүрээнд ажиллахын тулд дэргэдээ хуулийн зөвлөх ажиллуулах, өөртөө шүүмжлэлтэй буюу хариуцлагатай байхын баталгаа болсон омбудсмэн буюу уншигчдын өмгөөлөгчтэй байх боломжтой.

Бүтээлээ нийтийн хүртээл болгохын хувьд: Бие даасан сэтгүүл эрхлэн гаргах нь хараат бус үйл ажиллагаанд нь тустай. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь цаг хугацаа ихээхэн шаарддаг учраас сар хоёр сар тутмын сэтгүүл гаргавал илүү үр дүнтэй байна. Мөн Интернэтэд өөрсдийн Вэб хуудас байрлуулан, бүтээлээ нийтэд хүртээл болгон,

мэдээллийн хоёр чиглэлт урсгалыг бий болговол нийгэмд ашиг тустай байх болно.

Нийгэмд үзүүлэх үр нөлөөний хувьд: Монголд ардчилал бодит утгаараа хөгжихөд буюу нийт тогтолцооны хувьд эрүүл, ил тод, хариуцлагатай, иргэн хүний оролцоотой, хүн бүр хуулийн өмнө тэгш эрх байх зарчмыг хангасан нийгмийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байх болно.

НОМ ЗҮЙ

1. Ullmann J. The reporter's handbook An investiator's guide to documents and techniques (second education). New York., 1989
2. Засурский Я.Н. Сэтгүүлчийн эрх чөлөө, бие даасан байдал: өөрийн цензур, өөрийн хяналт. “Сэтгүүлч”, 1996. №1
3. Жереми П. Авилгалын эсрэг сурвалж бичиг. УБ., 2003
4. Тертычный А. Расследовательская журналистика. Москва., 2001
5. Тоби.М. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба эрэн сурвалжлах сэтгүүл зүй (лекц). МХХ. 1998
6. Баасансүрэн Т. Сэтгүүлчийн ур чадварын тухай яриа. УБ., 1999. х.83
7. Ч.Базар. Бодлогын судалгааны явцад хийсэн тандалтын судалгаа
8. Дашдондов Ц. Хэвлэл мэдээлэл, коррупци., ”Монголын мэдээ”, 2000, № 14
9. Зулькафиль М. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй: онол, практик, арга зүй. УБ., 2002
10. Цэмбэл Д. Цэнджав До. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол практикийн асуудал. УБ., 2000, х. 19
11. Д.Цэрэнжав. Хэвлэлийн ажиглалт”, 2005
12. Чимид. Б. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө. Сэтгүүлч ба хуульч. цувралын №3. УБ., 2001
13. Авилгалын эсрэг Монгол улсын хууль. Хоёрдугаар бүлэг, 11 дүгээр зүйлийн 1.2. “Төрийн мэдээлэл”, 2006
14. Авилгалын эсрэг цуврал уулзалт, ярилцлагын товч тэмдэглэл. УБ., Засгийн газрын архив, 2003
15. Авилгал ба хэвлэл мэдээлэл (Үндэсний шударга ёсны тогтолцоо, түүний үзүүлэлтүүд номын бүлэг). УБ., 2003, х. 96
16. Монгол дахь чөлөөт сэтгүүл зүйн зарим асуудал. УБ., 2002, х. 60
17. Монгол дахь чөлөөт сэтгүүл зүйн зарим асуудал. УБ. 2002. х.6
18. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлын тухай судалгааны тойм. УБ., 1998
19. Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал. “Глоб Интернэшнл” ТББ. УБ., 2007
20. Монголын хэвлэлийн эрх чөлөө. “Глоб Интернэшнл” ТББ. УБ., 2007
21. Нэр төр, гүтгэлэг. “Глоб Интернэшнл” ТББ. УБ., 2001
22. Олон нийтийн мэдэх эрх, мэдээллийн эрх чөлөө. “Глоб интернэшнл” ТББ., УБ., 2002
23. Олон нийтийн санал бодол, чөлөөт хэвлэлийн төлөвшил /судалгааны тойм. УБ., 2003
24. Хэвлэл мэдээллийн мониторингийн судалгаа, УБ., МХХ, 2007

25. Эрүүгийн байцаан шийтгэх тухай Монгол Улсын хуулийн 110 дугаар зүйл.
Доромжлох
26. Эрүүгийн байцаан шийтгэх тухай Монгол Улсын хуулийн 111 дүгээр зүйл.
Гүтгэх

ВЭБ САЙТ

1. www.pcij.org
2. www.ajr.newslink.org
3. www.emedia.editorandpublisher.com
4. www.searchenginecolossus.com